



САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА



ЖИЛИЙН ТАЙЛАН 2019



Санхүүгийн мэдээллийн алба нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн мөнгө угаах гэмт хэрэг, түүнд холбогдох гэмт хэрэг, зөрчил болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой мэдээллийг хүлээн авах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, шаардлагатай тохиолдолд дүн шинжилгээний үр дүнг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлэх үндсэн чиг үүрэгтэйгээр Монголбанкны дэргэд байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.

Санхүүгийн мэдээллийн албаны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг
<https://fiu.mongolbank.mn/> цахим хуудаснаас авна уу.

Санхүүгийн мэдээллийн алба, Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага Тойруу 3, 15160

Утас: (976-11) 32 34 34, Факс: (976-11) 31 14 71, И-мэйл: fiuforpublic@mongolbank.mn

АГУУЛГА

АНГЛИ НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	6
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	6
ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ	7
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ	8
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА	10
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	11
БҮЛЭГ 1. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	13
1.1 Дотоодын хууль, эрх зүйн баримт бичгүүд	13
1.2 Олон улсын эрх зүйн баримт бичгүүд	14
БҮЛЭГ 2. МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДЭЭС МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ	16
2.1 Мэдээлэл цуглуулах	16
2.2 Мэдээлэлд дүн шинжилгээ хийх	19
2.3 Мэдээлэл солилцох	20
2.3.1 Дотоодын байгууллагатай мэдээлэл солилцох	20
2.3.2 Гадаадын байгууллагатай мэдээлэл солилцох	21
БҮЛЭГ 3. ДОТООД БА ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА	22
3.1 Дотоод хамтын ажиллагаа	22
3.1.1 Үндэсний зөвлөл	22
3.1.2 Хамтын ажиллагааны зөвлөл	25
3.2 Гадаад хамтын ажиллагаа	28
3.2.1 ФАТФ болон АНДМУТБ	28
3.2.2 ЭГМОНТ бүлэг	30
3.2.3 Харилцан ойлголцлын санамж бичиг	30
3.3 Олон улсын хамтын ажиллагааны техник туслалцаа	31
БҮЛЭГ 4. ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ, НӨӨЦ БОЛОЛЦООГ САЙЖРУУЛАХ	33
4.1 Комплаенс ба сургалт	33
4.2 СМА-аас холбогдох байгууллагуудад хийсэн сургалт, семинар	35
БҮЛЭГ 5. ТИПОЛОГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ КЕЙС	37
5.1 Типологи 1	37
5.2 Типологи 2	38
БҮЛЭГ 6. МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН БҮТЭЦ	39
6.1 СМА-ны дотоод мэдээллийн системийн бүтэц	39
6.2 СМА-ны программ хангамж	40
6.3 GoAML программ хангамжийн тухай	41
6.4 Бусад	41

БҮЛЭГ 7. ҮНДЭСНИЙ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ 42**БҮЛЭГ 8. АНДМУТБ ХАРИЛЦАН ҮНЭЛГЭЭ БОЛОН ОУХАХБ-ЫН ДҮГНЭЛТ 44**

8.1. АНДМУТБ-ийн мөнгө угаах тогтолцоог үнэлэхтэй холбоотой харилцан үнэлгээ	44
8.1.1. АНДМУТБ-ийн Монгол Улсад хийсэн харилцан үнэлгээ	44
8.1.2. Харилцан үнэлгээний үр дүнг сайжруулах зорилгоор 2017-2019 онуудад авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	46
8.1.3. Үзүүлсэн ахиц дэвшлээс үүдэн үнэлгээг ахиулах нь	47
8.2 ОУХАХБ болон ФАТФ-аас Монгол Улсад хийсэн дүгнэлт	48
8.2.1. ОУХАХБ-ийн дүгнэлт	48
8.2.2. ФАТФ-аас Монгол Улсыг хяналтанд оруулсан тухай мэдэгдэл	48
8.2.3. ФАТФ-ын хяналтаас гарах ажлын төлөвлөгөө	48
8.3. ФАТФ-ын жагсаалтын нөлөө	49

БҮЛЭГ 9. ХЯНАЛТ ШАЛГАЛТ 50

9.1 Банкны МУТСТ үйл ажиллагааны хяналт шалгалт	51
9.2 Банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд хийгдсэн хяналт шалгалт	51

ХАВСРАЛТ 53

ЗУРАГНЫ ЖАГСААЛТ

Зураг 1.	СМА-ны цуглуулах мэдээллийн төрөл	16
Зураг 2.	Бэлэн мөнгө болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлангийн тоо /2017-2019/	17
Зураг 3.	Сэжигтэй гүйлгээний тайлангийн тоо /2017-2019/	17
Зураг 4.	2017-2019 онд хүлээн авсан гаалийн мэдүүлгийн тайлангийн тоо болон алт тушаалтын тоо	18
Зураг 5.	СГТ, дүн шинжилгээ хийгдсэн болон хийгдэж байгаа СГТ-гийн тоо /2017-2019/	19
Зураг 6.	СМА-ны эрх бүхий байгууллагуудтай мэдээлэл солилцсон байдал	20
Зураг 7.	Үндэсний зөвлөлийн бүтэц	22
Зураг 8.	Хамтын ажиллагааны зөвлөлийн бүтэц	25
Зураг 9.	ҮЗ, ХАЗ-ийн хуралдсан байдал /2017-2020/	26
Зураг 10.	СМА-аас зохион байгуулсан сургалт, семинар болон оролцогчдын тоо /2008-2019/	35
Зураг 11.	Бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалт, семинар болон оролцогчдын тоо /2008-2019/	35
Зураг 12.	СМА-нд ирүүлэх тайлангийн шаардлага	39
Зураг 13.	СМА-ны дотоод мэдээллийн системийн бүтэц	40
Зураг 14.	GoAML программ хангамжийн үйлдлүүд	41
Зураг 15.	МУТСТ чиглэлээр хяналт шалгалт хийх үйл ажиллагаа	50

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	2017-2019 онд хүлээн авсан БМГТ болон ГТТГТ-гийн тоо	17
Хүснэгт 2.	Эгмонт сүлжээгээр мэдээлэл солилцсон байдал	21
Хүснэгт 3.	Техник хэрэгжилтийн үнэлгээний үр дүн – 2017 он	45
Хүснэгт 4.	Үр дүнтэй байдлын үнэлгээний үр дүн – 2017 он	46
Хүснэгт 5.	Харилцан үнэлгээний тайлангаар хангалтгүй үнэлгээ авсан Техник хэрэгжилтийн үнэлгээг ахиулсан	47
Хүснэгт 6.	Ажлын төлөвлөгөөний төсөлд тусгасан ажлууд	49
Хүснэгт 7.	Банканд хийгдсэн хяналт шалгалтын тоо /2017-2019/	51
Хүснэгт 8.	Банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд хийгдсэн хяналт шалгалтын тоо /2017-2019/	52

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1.	Бусад орны СМА-нуудтай байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичиг (ХОСБ)	53
Хавсралт 2.	Төрийн болон төрийн эрх үүргийг хэрэгжүүлэгч төрийн бус байгууллага, өөрөө удирдах байгууллагуудад чиглэсэн соён гэгээрүүлэх ажлын үр дүн	54
Хавсралт 3.	СББМҮҮ-дэд хийсэн сургалт, семинар, форум, хэлэлцүүлэг, уулзалтын мэдээлэл	55
Хавсралт 4.	Техник туслалцаа	58
Хавсралт 5.	СББМҮҮ-д хүрч ажиллах ажлын хүрээнд хийсэн сургалтууд	59
Хавсралт 6.	Хамтарсан хяналт шалгалтын хүрээнд хийсэн уулзалтууд	59
Хавсралт 7.	Хуульч, нотариатч, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нарт хийсэн хяналт шалгалт	60
Хавсралт 8.	СМА-ны ажилтнуудын 2018-2019 онд оролцсон дотоод арга хэмжээний жагсаалт	60
Хавсралт 9.	СМА-ны ажилтнуудын 2018-2020.I онуудад оролцсон гадаад арга хэмжээний жагсаалт	62
Хавсралт 10.	Монгол улсын ФАТФ-ын техник хэрэгжилтийн болон үр дүнтэй байдлын үнэлгээний цаг хугацааны матриц (2007-2020)	63

АНГЛИ НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Товчлол /Англи/	Нэр томьёо /Англи/	Товчлол /Монгол/	Нэр томьёо /Монгол/
AML/CFT	Anti-money laundering/ countering financing of terrorism	МУТСТ	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
APJG	Asia Pacific Joint Group	АНДХБ	Ази, Номхон далайн хамтарсан бүлэг
APG	Asian Pacific group on Money Laundering	АНДМУТБ	Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг
BNI	Bearer negotiable instrument	ШТХ	Шилжих төлбөрийн хэрэгсэл
CC	Cooperation council	ХАЗ	Хамтын ажиллагааны зөвлөл
CFT	Countering financing of terrorism	ТСТ	Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
DNFBP	Designated non-financial business providers	СББМҮҮ	Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч
EAG	Euro-Asia group	ЕАМУТБ	Евро-Азийн мөнгө угаахтай тэмцэх бүлэг
FSRB	FATF-style regional bodies	ФТБНБ	ФАТФ-ын төрлийн бүс нутгийн байгууллага
FATF	Financial action task force	ФАТФ	Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага
FIU	Financial information unit	СМА	Санхүүгийн мэдээллийн алба
FUR	Follow-up report		Явцын тайлан
IO	Immediate outcomes	ШХ	Шууд хэрэгжилт
ICRG	International cooperation review group	ОУХАХБ	Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлэг
MER	Mutual evaluation report	ХҮТ	Харилцан үнэлгээний тайлан
NC	National council	ҮЗ	Үндэсний зөвлөл
PEP	Politically exposed person	УТНБЭ	Улс төрд нөлөө бүхий этгээд
POPR	Post observation period report		Ажиглалтын дараах тайлан
	Progress report		Ахицын тайлан
RBA	Risk based approach	ЭСА	Эрсдэлд суурилсан аргачлал
VASP	Virtual asset service provider	ВХҮҮ	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АНДМУТБ	Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг
АНДХБ	Ази, Номхон далайн хамтарсан бүлэг
БМГТ	Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ГТТГТ	Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлан
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
МУТСТ	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
МУТС	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх
ОУХАХБ	Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлэг
СББМҮҮ	Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
СГТ	Сэжигтэй гүйлгээний тайлан
УТНБЭ	Улс төрд нөлөө бүхий этгээд
ҮЗ	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөл
ФАТФ	Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага
ХАЗ	Хамтын ажиллагааны зөвлөл
ХЗХ	Хадгаламж, зээлийн хоршоо



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Мөнгө угаах болон терроризмыг
санхүүжүүлэхтэй тэмцэх
Монгол Улсын тогтолцоонд
гарсан өөрчлөлтүүдийн
он цагийн дараалал

2004.06 | Монгол Улс АНДМУТБ-д
гишүүнээр элсэв.

2006.07.08 | Монгол Улсын анхны Мөнгө угаах болон
терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
тухай хууль батлагдав.

2006.11.29 | Санхүүгийн мэдээллийн алба
байгуулагдав.

2007.07.01 | Монгол Улсын анхны Харилцан үнэлгээг
АНДМУТБ хийв.

2008.01.01 | СМА нь хуульд заасан тайлан,
мэдээллийг хүлээн авч эхлэв.

2009.05.29 | Монгол улс Эгмонт бүлэгт
гишүүнээр элсэв.

2011.06 | Монгол Улс МУТСТ хяналтын тогтолцоог
сайжруулах үүрэг хүлээв.

2013.05.31 | МУТСТ тухай хуулийг шинэчлэв.

2017.09.05 | АНДМУТБ-ээс Монгол Улсын 2 дахь
шатны харилцан үнэлгээг хийв.

2018.04.26 | Мөнгө угаах болон терроризмыг
санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд
нэмэлт өөрчлөлт оруулав.

2019.10 | Монгол Улс ФАТФ-ын стратегийн
дутагдалтай орны жагсаалтад оров.

2020.01 | СМА нь СББМҮҮ-ээс хуульд заасан тайлан,
мэдээллийг авч эхлэв.

2020.02 | ФАТФ-аас өгөгдсөн нийт үүрэг
даалгаврын 50%-ийг биелүүлэв.

2020.04 | Монгол Улс Үндэсний эрсдэлийн үнэлгээ
хийж байна.

2020.05 | АНДХБ-т цахимаар үлдсэн ажлуудаа
хамгааллаа.

2020.06 | ФАТФ-аас өгөгдсөн 6 ажлын үүрэг
даалгаврыг биелүүлэв.

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт уншигч танд Санхүүгийн мэдээллийн албанаас гаргаж буй анхны жилийн тайлан хүрэх өдрийн мэндийг хүргэе.

Санхүүгийн мэдээллийн алба нь 2006 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу байгуулагдсан бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангуулах, Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоог олон улсын стандарт, шаардлагад нийцүүлэх, улмаар банк, санхүүгийн системийн тогтвортой байдал, найдвартай ажиллагааг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлж ирлээ.

Энэхүү жилийн тайлангаар бид Санхүүгийн мэдээллийн албаны үйл ажиллагааны талаарх танилцуулга, 2019 онд хийсэн ажлууд болон Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлж сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлуудын талаар танилцуулахыг зорив.

Үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд Санхүүгийн мэдээллийн алба нь 2019 онд мэдээлэх үүрэгтэй этгээдээс 20 сая төгрөг болон түүнээс дээш дүнтэй нийт 562,926 бэлэн мөнгөний гүйлгээ болон 131,715 гадаад төлбөр тооцооны гүйлгээ, 2,385 сэжигтэй гүйлгээний мэдээлэл хүлээн авсан бол хилээр бэлнээр нэвтрүүлсэн 15 сая төгрөгөөс дээш дүнтэй нийт 11,870 гаалийн мэдүүлэг хүлээн авчээ. 2019 онд хүлээн авсан сэжигтэй гүйлгээний тоог 2018 онтой харьцуулахад 49 хувиар, гадаад төлбөр тооцооны гүйлгээний тоо 4 хувиар, гаалийн мэдүүлгийн тоо 8 дахин өссөн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд нийт 84 сэжигтэй гүйлгээний мэдээлэлд дүн шинжилгээ хийж, 48 сэжигтэй гүйлгээний мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлжээ. Түүнчлэн мөнгө угаах, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр дотоодын эрх бүхий байгууллагууд болоод гадаад улсын ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудтай хууль тогтоомжийн хүрээнд мэдээлэл солилцож, хамтран ажиллалаа.

Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог олон улсын стандартад нийцүүлж, хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлэх, хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан хэлбэрт шилжүүлэх, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг эрсдэлд суурилан гүйцэтгэх, хуулийн нэр томъёоны тодорхойлолтуудыг олон улсын стандартад нийцүүлэх, хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг эрс чангатгах чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгууллаа. Мөн холбогдох төрийн байгууллагууд, мэдээлэх үүрэгтэй этгээд болон олон нийтэд

зориулан мэдлэг, мэдээлэл түгээх ажлуудыг хийж гүйцэтгэн, хэвлэмэл бүтээгдэхүүн, брошур хэвлэж тараах, уулзалт, сургалт семинар зохион байгуулах зэрэг соён гэгээрүүлэх ажлуудыг хийв.

Энэ нэг жилийн хугацаанд Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнуудын чадавхийг нэмэгдүүлэх чиглэлээр олон улсын байгууллагуудаас техник туслалцаа авах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулсан бөгөөд мэдээлэл хүлээн авах, дүн шинжилгээ хийх ажлыг олон улсын түвшинд хүргэх зорилгоор мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд зориулж тусгайлан хөгжүүлсэн програм хангамж худалдаж авах гэрээ байгуулж, албаны орон тоог нэмэгдүүлэх ажлыг эхлүүлэв.

Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх байгууллагаас Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны хоёр дахь удаагийн үнэлгээг 2016-2017 онд хийсэн бөгөөд харилцан үнэлгээний үр дүн, манай улсын зүгээс авч хэрэгжүүлсэн ажлуудаар шууд хэрэгжилтийн болон техник хэрэгжилтийн зөвлөмжүүдийн үнэлгээг ахиулсан. Гэсэн хэдий ч Монгол Улсыг Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтад 2019 оны 10 дугаар сард оруулсан. Иймээс 2019 он бол манай албаны хувьд төдийгүй Монгол Улсын хувьд ФАТФ-ын “Өргөтгөсөн эрчимтэй хяналт”-аас гарах хүнд бөгөөд амаргүй сорилттой нүүр тулсан жил байлаа.

Монгол Улс ФАТФ-ын хяналтаас бүрэн гарах зорилгоор 2021 оны 5 дугаар сар хүртэл авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан үйл ажиллагааны төлөвлөгөөг ФАТФ-тай хамтран боловсруулсан. Санхүүгийн мэдээллийн албаны хувьд хуульд заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх, төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг богино хугацаанд, чанартай гүйцэтгэх ажлыг зохион байгуулж, оролцогч байгууллага хоорондын үйл ажиллагааг уялдуулах, нэгтгэх чиглэлээр өөрийн хүч, нөөц бололцоог дайчлан ажиллах болно.

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН

АЛБАНЫ ДАРГА

Б.БАТБААТАР



САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА


Санхүүгийн мэдээллийн алба (СМА)-нь МУТСТ тухай хуульд заасан мэдээлэх үүрэгтэй этгээдээс тайлан, мэдээллийг хүлээн авах, дүн шинжилгээ хийх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүй мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлэх үндсэн чиг үүргүүдийг хэрэгжүүлж ажилладаг. Түүнчлэн СМА нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр гадаад болон дотоодын эрх бүхий байгууллагуудтай ажиллах, МУТСТ үйл ажиллагааг олон нийтэд таниулах, хяналт тавих зэрэг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ. СМА нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ зүй бус хөндлөнгийн оролцоо, нөлөөллөөс ангид байдлаар биелүүлэхийн тулд хангалттай бие даасан статустай байх ёстой.

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх (МУТС)-ээс урьдчилан сэргийлэх олон улсын стандарт болох Техник хэрэгжилтийн 40 Зөвлөмж, үр дүнтэй байдлын 11 Шууд хэрэгжилтийг боловсруулан гаргасан. Уг стандартын Зөвлөмж 29-т СМА-ны эрхлэх үйл ажиллагааны стандартыг тодорхойлон тусгасан байдаг.

Монгол Улс нь ФАТФ-ын бүс нутаг хариуцсан байгууллага болох Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг (АНДМУТБ)-ийн гишүүнээр 2004 онд элсэн орж, одоог хүртэл ФАТФ-аас гаргасан олон улсын стандартын дагуу Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) тогтолцоогоо тогтмол үнэлүүлж ирсэн.

Монгол Улс 2006 оны 7 дугаар сарын 08-ны өдөр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг баталснаар СМА-ыг байгуулжээ. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу Монголбанкны дэргэд байгуулагдсан СМА нь олон улсын зарчим, стандартыг хэрэгжүүлэхийн төлөө үйл ажиллагаагаа явуулсаар ирсний үр дүнд олон улсад хүлээн зөвшөөрөгдөж Эгмонт бүлэгт 2009 онд элсэн орсон. Энэ хүрээнд СМА нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх урьдчилан сэргийлэх чиглэлээр бусад улс орны СМА-уудтай мэдээлэл солилцон хамтран ажиллаж байна.

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС

- Мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн, түүнчлэн эрх бүхий төрийн болон гадаад улсын ижил төстэй байгууллагын мэдээллийн санд байгаа мэдээллийг хүлээн авах, цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийх;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үндэслэлтэй гүйлгээ байна гэж үзсэн тохиолдолд тухайн мэдээллийг хуульд заасан журмын дагуу эрх бүхий хууль сахиулах болон терроризмтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагад шилжүүлэх, шилжүүлсэн сэжигтэй бэлэн ба бэлэн бус мөнгөний гүйлгээний талаар мэдээллийн сан бүрдүүлэх;
- Мэдээлэх үүрэгтэй этгээдийн сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор сэжигтэй гүйлгээнд хийсэн дүн шинжилгээний талаарх ерөнхий мэдээлэл, сэжигтэй гүйлгээний нийтлэг хэв шинж, арга хэлбэрийн талаар тогтмол мэдээлэх;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдсон мэдээллийг шалгах, сэжигтэй гүйлгээг хянах, илрүүлэх аргачлал боловсруулж мэдээлэх үүрэгтэй этгээдэд мэдээлэх, хэрэгжилтийг нь зохион байгуулах;
- Программын тасралтгүй ажиллагааг хангах, сервер, компьютер, техник тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа, нууцлал, аюулгүй байдлыг хангах ажлуудыг удирдан зохион байгуулах.

БОДЛОГО ХЭРЭГЖИЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС

- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар олон нийтийн дунд мэдээлэл, сурталчилгаа явуулах;
- Хориг арга хэмжээний жагсаалтыг мэдээлэх үүрэгтэй этгээдэд мэдээлэх, хэрэгжилтийг нь зохион байгуулах;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтын талаар нэгдсэн статистик гаргах, хяналт шалгалт хийх, эрх бүхий бусад этгээдээр хяналт шалгалт хийлгэх;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх, уг үнэлгээний үр дүнд суурилсан үндэсний стратеги боловсруулах, уг стратегийг Хамтын ажиллагааны зөвлөлөөр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг зохион байгуулах;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр гадаад болон дотоодын эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах.



БҮЛЭГ 1

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль 2006 оны 7 дугаар сард батлагдсанаар Монгол Улсад МУТСТ үйл ажиллагааны үндэс суурь тавигдсан. Ингэснээр дотоодын хууль, эрх зүйн баримт бичиг, олон улсын стандартад нийцүүлэн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, эрх зүйн орчинг сайжруулан ажиллаж байна. Энэхүү тогтолцоог бэхжүүлэхэд одоогоор мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн баримт бичгүүдээс дурдвал:

1.1 ДОТООДЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД

ХУУЛЬ:

- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль;
- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль;
- Зөрчлийн тухай хууль;
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль.

ЖУРАМ, ЗААВАР, ХӨТӨЛБӨР:

- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А-326 тоот тушаалын хавсралтаар батлагдсан Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам;
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А-26 тоот тушаалын хавсралтаар батлагдсан МУТС-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам;

- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А-293 тоот тушаалын хавсралтаар батлагдсан Мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэргүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх банкны үйл ажиллагаанд Монголбанкнаас газар дээрх хяналт, шалгалт хийх журам;
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А-293 тоот тушаалын хавсралтаар батлагдсан Мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэргүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх банкны үйл ажиллагаанд Монголбанкнаас зайнаас хяналт тавих журам;
- Банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зориулсан журам, заавар;
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 464 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журам;

- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 143 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөр;
- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 327 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө.

ЗӨВЛӨМЖ, УДИРДАМЖ, ГАРЫН АВЛАГА:

- Зорилтод санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх гарын авлага;
- Улс төрд нөлөө бүхий этгээдийг тогтоох талаар мэдээлэх үүрэгтэй этгээдэд зориулсан гарын авлага;
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А-32 тоот тушаалын хавсралтаар батлагдсан МУТСТ үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан зарчмыг хэрэгжүүлэх удирдамж;
- Эцсийн өмчлөгчийн тухай гарын авлага;

- СББМҮҮ-дэд зориулсан СМА-д Мэдээлэх үүрэгтэй этгээд (МЭҮЭ)-ээс цахимаар мэдээлэл ирүүлэх журмын дагуу тайлан бөглөх заавар, зөвлөмж;
- Нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх гарын авлага;
- Хуульчдад зориулсан эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх гарын авлага;
- Нотариатчдад зориулсан эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх гарын авлага;
- МУТСТ олон нийтэд зориулсан гарын авлага;

ТАЙЛАН, ҮНЭЛГЭЭ:

- Монгол Улсын 2016 оны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээ;
- Стратегийн дүн шинжилгээний тайлан;
- Типологийн тайлан;
- Хуулийн этгээдийн төрлөөр хийсэн эрсдэлийн үнэлгээний тайлан.

1.2 ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД

ФАТФ-ААС ГАРГАСАН МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ БОЛОН ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСГИЙГ ДЭЛГЭРГҮҮЛЭХИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ОЛОН УЛСЫН СТАНДАРТ

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандартыг ФАТФ-ын 2019 оны 6 дугаар сарын чуулганаар шинэчилсэн байдлаар батлав.
- ФАТФ-ын зөвлөмжийг олон улсын МУТСТ стандарт гэж хүлээн зөвшөөрдөг.
- Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг энэхүү стандартад нийцүүлэн баталсан.

МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТИЙН ЭСРЭГ НҮБ-ЫН КОНВЕНЦ

- 1988 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталж, 1990 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр хүчин төгөлдөр болсон.
- Монгол Улс энэхүү конвенцид 2003 оны 6 дугаар сарын 25-ны өдөр нэгдэн орсон.
- Энэхүү конвенцын зорилго нь олон улсын хэмжээний асуудал болж байгаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй холбоотой олон төрлийн асуудлыг үр өгөөжтэйгээр шийдвэрлэх талуудын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино. Талууд энэхүү конвенцын дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхдээ өөрийн дотоодын хууль тогтоомжийн тогтолцооны үндсэн зарчимд нийцүүлэн хуулийн болон захиргааны шаардлагатай арга хэмжээ авна.

ҮНДЭСТЭН ДАМНАСАН ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ГЭМТ ХЭРГИЙН ЭСРЭГ НҮБ-ЫН КОНВЕНЦ

- 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр баталж, 2003 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр хүчин төгөлдөр болсон.
- Монгол Улс 2008 оны 6 дугаар сарын 27-ны өдөр нэгдэн орсон.
- Энэхүү конвенцын зорилго нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргээс илүү үр дүнтэй урьдчилан сэргийлэх болон түүнтэй тэмцэх хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.

ҮНДЭСТЭН ДАМНАСАН ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ГЭМТ ХЭРГИЙН ЭСРЭГ НҮБ-ЫН КОНВЕНЦЫН НЭМЭЛТ БОЛОХ ГАЛТ ЗЭВСЭГ, ТҮҮНИЙ БҮРДЭЛ ХЭСЭГ, ЭД АНГИ БОЛОН ГАЛТ ХЭРЭГСЛИЙГ ХУУЛЬ БУСААР ТЭЭВЭРЛЭХ, ҮЙЛДВЭРЛЭХИЙН ЭСРЭГ ПРОТОКОЛ

- 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр баталж, 2004 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр хүчин төгөлдөр болсон.
- Монгол Улс 2008 оны 6 дугаар сарын 27-ны өдөр нэгдэн орсон.
- Энэхүү протоколын зорилго нь шилжин суурьшигчдыг хууль бус оруулахаас урьдчилан сэргийлэх болон түүнтэй тэмцэх, түүнчлэн ийнхүү зорилтод хүрэх үүднээс оролцогч улсын хоорондын хамтын ажиллагааг дэмжих, үүний зэрэгцээ хууль бус оруулсан шилжин суурьшигчдын эрхийг хамгаалахад оршино.

АВЛИГЫН ЭСРЭГ НҮБ-ЫН КОНВЕНЦ

- 2003 оны 10 дугаар сарын 14-ний өдөр баталж, 2005 оны 12 дугаар сарын 14-ний өдөр хүчин төгөлдөр болсон.
- Монгол Улс 2005 оны 10 дугаар сарын 27-ны өдөр соёрхон баталсан.
- Энэхүү конвенцын зорилго нь:
 - а) Авлигаас илүү үр ашигтай бөгөөд үр дүнтэйгээр урьдчилан сэргийлж, тэмцэх арга хэмжээг хөхүүлэн дэмжиж, бэхжүүлэх;
 - б) Авлигаас урьдчилан сэргийлж, тэмцэх, түүний дотор хөрөнгө буцааж олгох талаар олон улсын хамтын ажиллагаа, техник туслалцааг хөхүүлэн дэмжих, хөнгөвчлөн дэмжих;
 - в) Нийтийн хэрэг, нийтийн эд хөрөнгийн үнэн шударга, хариуцан тайлагнах, зохистой удирдлагыг хөхүүлэн дэмжихэд оршино.

ҮНДЭСТЭН ДАМНАСАН ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ГЭМТ ХЭРГИЙН ЭСРЭГ НҮБ-ЫН КОНВЕНЦЫН НЭМЭЛТ БОЛОХ ХҮН ЯЛАНГУЯА ЭМЭГТЭЙЧҮҮД, ХҮҮХЭД ХУДАЛДААЛАХААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТАСЛАН ЗОГСООХ, ШИЙТГЭХ ТУХАЙ ПРОТОКОЛ

- 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр баталж, 2003 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хүчин төгөлдөр болсон.
- Монгол Улс 2008 оны 6 дугаар сарын 27-ны өдөр нэгдэн орсон.
- Энэхүү протоколын зорилго нь:
 - а) Хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх ба түүнтэй тэмцэх, ингэхдээ эмэгтэйчүүд, хүүхдүүдийн хувьд тусгайлан анхаарал тавих;
 - б) Хүн худалдаалах хэргийн хохирогчдын хүний эрхийг бүрэн хүндлэн тэднийг хамгаалах ба туслалцаа үзүүлэх; болон
 - в) Эдгээр зорилтод хүрэх үүднээс оролцогч улсын хоорондын хамтын ажиллагааг дэмжихэд оршино.

ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ

- 1999 оны 12 дугаар сарын 9-ний өдөр баталж, 2002 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр хүчин төгөлдөр болсон.
- Монгол Улсын 2004 оны 2 дугаар сарын 25-ны өдөр нэгдэн орсон.

БҮЛЭГ 2

МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДЭЭС МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

2.1 МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ

СМА нь мөнгө угаах гэмт хэрэг, түүнд холбогдох гэмт хэрэг, зөрчил болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой мэдээллийг хүлээн авах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, дүн шинжилгээний үр дүнд МУТС-тэй холбоотой гэж сэжиглэсэн гүйлгээ, гүйлгээний оролдлогын талаарх мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлэх чиг үүрэгтэй. Мөн СМА нь МУТС-т тухай хуульд заасан журмын дагуу цуглуулсан мэдээллийг нэгтгэсэн мэдээллийн сантай байна.

СМА нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу бэлэн мөнгөний гүйлгээний тайлан, сэжигтэй гүйлгээний тайлан, гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлан, гаалийн мэдүүлгийн тайлангийн мэдээллийг цуглуулдаг.




Зураг 1. СМА-ны цуглуулах мэдээллийн төрөл

Хүснэгт 1. Бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны тоо (2017-2019)

Тайлангийн нэр	2017 он	2018 он	2019 он
Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан	572,181	669,910	562,926
Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлан	98,549	126,944	131,715

Эх сурвалж: Монголбанк, СМА

БЭЛЭН МӨНГӨ БОЛОН ГАДААД ТӨЛБӨР ТООЦООНЫ ГҮЙЛГЭЭНИЙ ТОО (2017-2019)



Зураг 2. Бэлэн мөнгө болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлангийн тоо /2017-2019/

СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН


Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг МУТС-тэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол мэдээлэх үүрэгтэй этгээд нь энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу СМА-д мэдээлэх үүрэгтэй.

Одоогоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А-326 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам"-ын дагуу мэдээлэх үүрэгтэй этгээд нь СМА-д тайлан ирүүлдэг.

Сэжигтэй гүйлгээний тухай мэдээлэл нь тухайн гүйлгээтэй холбоотой бүхий л хэрэгтэй мэдээллийг агуулсан байх шаардлагатай.



СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ТОО /2017-2019/



Зураг 3. Сэжигтэй гүйлгээний тоо /2017-2019/

Эх сурвалж: Монголбанк, СМА

СМА-д ирүүлсэн СГТ-гийн 99% хувь нь банкнаас ирсэн байна.


Үзүүлэлт	2017	2018	2019
Банк	203	1,593	2,370
Банкнаас бусад	0	3	15

ГААЛИЙН МЭДҮҮЛГИЙН ТАЙЛАН

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын хилээр зорчигч 15 саяас дээш төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют, санхүүгийн хэрэгсэл, цахим мөнгийг Монгол Улсын хилээр бэлнээр нэвтрүүлэх бол энэ тухай гаалийн мэдүүлэгт үнэн зөв мэдүүлнэ. Үүний дагуу мэдүүлсэн бэлэн мөнгөний мэдүүлгийг гаалийн байгууллага нэгтгэж, сар бүр холбогдох журмын дагуу СМА-д хүргүүлдэг. Гаалийн ерөнхий газраас хүлээн авсан хилээр бэлэн мөнгө нэвтрүүлсэн тухай гаалийн мэдүүлгийн тайлангийн тоог дараах зурагт харууллаа.

Зураг 4. 2017-2019 онд хүлээн авсан гаалийн мэдүүлгийн тоо

ГААЛИЙН МЭДҮҮЛГИЙН ТОО




Гаалийн мэдүүлгийн тоо 2019 онд огцом өссөн нь ФАТФ-ын хяналтаас гарах үйл ажиллагааны төлөвлөгөөний Шууд хэрэгжилт 8: Хилээр мэдүүлээгүй/худал мэдүүлсэн мөнгөн тэмдэгтийг хураан авах, битүүмжлэх үйл ажиллагааг үргэлжлүүлэх, гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлсэн арга хэмжээ авч хэрэгжүүлсэнтэй холбоотой.

2.2 МЭДЭЭЛЭЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 18.1.1-т заасны дагуу СМА нь мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн, түүнчлэн эрх бүхий төрийн болон гадаад улсын ижил төстэй байгууллагын мэдээллийн санд байгаа мэдээллийг хүлээн авах, цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийх үндсэн чиг үүрэгтэй. Үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд олон улсын стандарт болон “СМА-ны мэдээлэл хүлээж авах, боловсруулах, шилжүүлэх журам”-д заасны дагуу СМА нь үйл ажиллагааны (сэжигтэй гүйлгээнд хийх дүн шинжилгээ) болон стратегийн дүн шинжилгээ хийдэг. СМА-ны Үйл ажиллагааны хэлтсээс 2008-2019 онуудад нийт 5,392 сэжигтэй гүйлгээг хүлээн авч, холбогдох арга хэмжээг авсан байна.

Зураг 5. СГТ, дүн шинжилгээ хийгдсэн болон хийгдэж байгаа СГТ-гийн тоо /2017-2019/

ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙГДСЭН БОЛОН ХИЙГДЭЖ БАЙГАА СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ТОО (2017-2019)











Эх сурвалж: Монголбанк, СМА

Шинжээчид сэжигтэй гүйлгээнд дүн шинжилгээ хийхдээ мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн болон тэднээс нэмж авсан мэдээлэл, СМА-ны мэдээллийн сан дахь мэдээлэл, төрийн эрх бүхий байгууллага болон гадаад улсын СМА-ны мэдээллийн сангуудаас авдаг лавлагаа, бусад нээлттэй мэдээллийн эх үүсвэрийн мэдээллийг ашигладаг. Түүнд үндэслэж тухайн шалгаж буй этгээдийн санхүүгийн болон санхүүгийн бус үйл хөдлөлд ямар өөрчлөлт гарч байна, анхаарал татахуйц, сэжигтэй байж болзошгүй гүйлгээг хэнтэй, хэзээ, хаана, яаж, яагаад, ямар зорилгоор юу хийх өндөр магадлалтай байна гэдгийг олж тогтоохыг зорьж, судалгаа шинжилгээ хийдэг.

СМА-ны албан бүтэц, орон тоо нэмэгдэж, чадамжийг дээшлүүлэх арга хэмжээ авсны үр дүнд СГТ-д хийгдэж буй дүн шинжилгээний тоо, чанар сайжирч байна.

Харин стратегийн дүн шинжилгээ нь МУТС ерөнхий чиг хандлага, эрсдэлийг тодорхойлох, СМА болон холбогдох бусад байгууллагад МУТС, түүнээс урьдчилан сэргийлэх стратеги, бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, нөөц бололцоогоо зөв хуваарилах, эрсдэл болон аюул заналыг оновчтой удирдахад нь чиглэл, дэмжлэг өгөх зорилгоор илүү урт хугацааг хамарсан, МУТС-тэй холбоотой байж болох олон төрлийн, өргөн хүрээний мэдээллийг цуглуулж хийгддэг дүн шинжилгээ юм.

СМА нь 2019 онд анхны стратеги шинжилгээний тайланг гаргасан бөгөөд 2020 онд 2 дахь стратегийн дүн шинжилгээний тайланг боловсруулж гаргав.




2.3 МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ

2.3.1 ДОТООДЫН БАЙГУУЛЛАГАТАЙ МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 18.6-д зааснаар Санхүүгийн мэдээллийн алба нь үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр эрх бүхий байгууллагатай хамтран ажиллаж, мэдээлэл солилцож, гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлдэг. Энэ ажлын хүрээнд 2017-2019 онуудад СМА-ны хууль сахиулах байгууллагаас хүлээн авсан мэдээлэл хүссэн лавлагаа болон түүнд хариулсан байдлыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Зураг 6. СМА-ны эрх бүхий байгууллагуудтай мэдээлэл солилцсон байдал

СМА-НЫ ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУДАЙ МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦСОН БАЙДАЛ /2017-2019/



Эх сурвалж: Монголбанк, СМА

2.3.2 ГАДААДЫН БАЙГУУЛЛАГАТАЙ МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ

ФАТФ-ын Зөвлөмж 29-д зааснаар СМА нь Эгмонт бүлэг болон СМА-дын хооронд МУТС үйлдэлтэй холбоотой мэдээлэл солилцох зарчмыг харгалзан үзэх хэрэгтэй. Эдгээр бичиг баримтад СМА-ны эрх, үүрэг болон СМА-дын дунд мэдээлэл солилцох үйл явцтай холбоотой чухал зааврыг дурдсан байдаг юм. СМА-ны сүүлийн гурван жилийн байдлаар Эгмонт сүлжээгээр мэдээлэл солилцсон байдлыг дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 2. Эгмонт сүлжээгээр мэдээлэл солилцсон байдал

Үзүүлэлт	2017 он	2018 он	2019 он
СМА-аас гадаадын СМА болон ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудад явуулсан хүсэлтийн тоо	393	231	238
Гадаадын СМА болон ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудад явуулсан хүсэлтийн дагуу ирүүлсэн хариуны тоо	316	193	202
Гадаадын СМА болон ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудаас мэдээлэл авах чиглэлээр СМА-д ирүүлсэн хүсэлтийн тоо	167	126	133
Гадаадын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудаас мэдээлэл авах чиглэлээр СМА-д ирүүлсэн хүсэлтийн дагуу явуулсан хариуны тоо	151	126	144

Эх сурвалж: Монголбанк, СМА



БҮЛЭГ 3

ДОТООД БА ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

3.1 ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА

Монгол Улсын МУТСТ үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Үндэсний зөвлөл (ҮЗ) болон Хамтын ажиллагааны зөвлөл (ХАЗ) ажилладаг.

3.1.1. ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 22¹ дүгээр зүйлд ҮЗ-ийн эрх зүйн зохицуулалтыг тусгасан байдаг. Дээрх хуулийн 22¹-ийн 2 дугаар хэсэгт ҮЗ-ийн бүрэлдэхүүнд прокурорын байгууллага, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, санхүүгийн, хууль зүйн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эрх бүхий хууль сахиулах болон терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллага, татвар, гаалийн байгууллага, СМА-ны төлөөллийг оролцуулна гэж заасан байна. Иймд Монгол Улсын МУТСТ тогтолцоог бэхжүүлэх, ФАТФ-ын 2016-2017 оны явцын тайлангийн техник хэрэгжилтийн үр дүнтэй байдлын үнэлгээг хангах үүднээс анх Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 04 дугаар сарын 20-ны өдрийн 70 дугаартай захирамжаар ҮЗ-ийн бүрэлдэхүүнийг баталж байжээ. Тус захирамж нь 2018 оны 08 дугаар сарын 20-ны өдөр 144 дугаартай захирамжаар шинэчлэгдэн батлагдаж дараах бүтэцтэйгээр байгуулагдсан.

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

- Хууль зүй, дотоод хэргийн сайд (Зөвлөлийг даргална)
- Тагнуулын ерөнхий газрын дарга (Орлогч дарга)
- Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албаны дарга (Нарийн бичгийн дарга)
- Улсын ерөнхий прокурорын орлогч
- Авлигатай тэмцэх газрын дэд дарга
- Засгийн газрын хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга
- Сангийн дэд сайд
- Гадаад харилцааны дэд сайд
- Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга
- Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга
- Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд дарга
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тэргүүн дэд дарга
- Гаалийн ерөнхий газрын дэд дарга
- Татварын ерөнхий газрын дэд дарга
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэд дарга

Зураг 7. Үндэсний зөвлөлийн бүтэц
Эх сурвалж: Монголбанк, СМА



ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ НЬ ДАРААХ ЧИГ ҮҮРГИЙН ДАГУУ АЖИЛЛАНА. ҮҮНД:

Зөвлөл нь Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээнд үндэслэн мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого, стратеги бүхий хөтөлбөрийн төслийг боловсруулна;

Зөвлөлийн даргаар дамжуулан хөтөлбөрийн төслийг Засгийн газарт хүргүүлж, батлуулах арга хэмжээг авна;

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн хөтөлбөрийг шинэчлэн батална;

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх хүрээнд авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаарх шийдвэрийг хурлаар хэлэлцэн гаргана.

Зөвлөл нь хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, түүний биелэлтийг үнэлэх, дараагийн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээг хийх ажлыг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангана;

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, холбогдох байгууллагатай хамтран ажиллана;

Хөтөлбөрийн хэрэгжилтийн биелэлтийг зөвлөл жил бүр дүгнэж, Засгийн газарт хүргүүлнэ;

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛӨӨС ХИЙСЭН ГОЛ АЖЛУУД

Үндэсний зөвлөлөөс Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулж, 2017 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Засгийн газрын 143 дугаар тогтоолын хавсралтаар батлуулав.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 327 дугаар тогтоолын хавсралтаар Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулсан.

2017 оны хоёр дугаар улирлаас хойш хийж гүйцэтгэсэн ажлуудын тайланг Засгийн газарт танилцуулсан.

2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийг Засгийн газраар хэлэлцүүлсэн бөгөөд тус хуульд 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан.

Холбогдох байгууллагуудаас 2018 оны эхний хагас жилд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээтэй танилцаж, цаашид авах шаардлагатай арга хэмжээг тусгасан зөвлөмж гаргахаар шийдвэрлэв.

Үндэсний зөвлөлийн 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн хурлаар “Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 40 зөвлөмжийн Техник хэрэгжилтийн дутагдлыг сайжруулах ажлын төлөвлөгөө”-г баталсан.

Үндэсний зөвлөлийн дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 5 дугаар сарын 26-ны өдрийн А/85 дугаар тушаалын хавсралтаар “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний зөвлөлийн ажиллах журам”-ыг баталсан.

3.1.2. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨЛ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу СМА-ны дэргэд МУТСТ тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мэдээлэл солилцох, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий ХАЗ ажилладаг.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль 2006 онд батлагдаж ХАЗ-ийн үйл ажиллагааг анх хуульд тусгаж байжээ. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 160 дугаартай тушаалаар ХАЗ-ийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг анх батлаж байв. Түүнээс хойш ХАЗ-ийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг хэд хэдэн удаа шинэчлэн баталж байсан бөгөөд одоогоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 8 дугаар сарын 28-ны А-225 дугаартай тушаалын хавсралтаар баталсан ХАЗ-ийн бүрэлдэхүүн болон Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн А-229 дугаартай тушаалын хавсралтаар баталсан ХАЗ-ийн ажиллах журмын дагуу үйл ажиллагаа явуулж байна. ХАЗ-ийн бүрэлдэхүүнийг доорх жагсаалтад харууллаа. Үүнд:

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨЛ

- | | |
|---|----------------------------------|
| • Монголбанк | • Шүүхийн ерөнхий зөвлөл |
| • Санхүүгийн мэдээллийн алба | • Улсын ерөнхий прокурорын газар |
| • Тагнуулын ерөнхий газар | • Гадаад харилцааны яам |
| • Сангийн яам | • Терроризмтой тэмцэх зөвлөл |
| • Хууль зүй, дотоод хэргийн яам | • Авлигатай тэмцэх газар |
| • Санхүүгийн зохицуулах хороо | • Цагдаагийн ерөнхий газар |
| • Улсын дээд шүүх | • Улсын бүртгэлийн ерөнхий газар |
| • Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх | • Татварын ерөнхий газар |
| | • Гаалийн ерөнхий газар |

Зураг 8.Хамтын ажиллагааны зөвлөлийн бүтэц
Эх сурвалж: Монголбанк, СМА

Хамтын ажиллагааны зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг хурал хэлбэрээр явуулдаг бөгөөд Санхүүгийн мэдээллийн алба нь Хамтын ажиллагааны зөвлөлийн ажлын албыг хариуцан ажилладаг.



ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨЛ НЬ ДАРААХ ЧИГ ҮҮРЭГТЭЙ:

1 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох зөвлөмж, санал гаргах;

2 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг Монгол Улсын хэмжээнд судлах, эрсдэлийн үнэлгээ хийх, үр дүнг тооцох ажиллагааг тогтмол зохион байгуулах;

3 Үндэсний эрсдэлийн үнэлгээнд үндэслэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх, үр дүнтэй, оновчтой зохион байгуулах талаар зөвлөмж гаргах;

4 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх нөхцөл байдал, үр дүнгийн талаар мэдээлэл солилцох;

5 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллагын үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явагдаж буй эсэхтэй танилцаж мөрдүүлэх талаар санал, зөвлөмж гаргах;

6 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан дүрэм, журам, хөтөлбөр, төлөвлөгөөний болон ХАЗ-өөс гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг холбогдох байгууллага, албан тушаалтан хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих, гүйцэтгэлийн явцтай танилцах, шаардлагатай бол хэрэгжилтийг хангаж ажиллахыг шаардах, гүйцэтгэлийг ХАЗ-өөр хэлэлцүүлэх, хугацаатай үүрэг даалгавар өгөх, үйл ажиллагааны уялдаа холбоог хангуулах зэрэг холбогдох арга хэмжээг авах;

7 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг олон улсын стандарт, Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын 40 зөвлөмжид нийцүүлэх талаар санал гарган танилцуулах;

8 Гишүүн байгууллагын үйл ажиллагааг үндэсний болон бүс нутаг, олон улсын байгууллагын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажилтай уялдуулахад дэмжлэг үзүүлэх;

9 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үйл олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллага, хувийн хэвшил болон олон нийтэд зориулсан сургалт зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;

10 МУТСТ талаар өргөдөл, гомдлыг хүлээн авах, хянан шийдвэрлэх;

11 Санхүүгийн мэдээллийн албаны бүтэц, зохион байгуулалт, төсөв, үйл ажиллагааны зардлын талаар санал гаргах, танилцуулах, шийдвэрлүүлэх;

12 ХАЗ-ийн дэргэдэх Ажлын хэсгийн хэрэгжүүлж байгаа арга хэмжээтэй танилцах, хэрэгжүүлэх санал зөвлөмж, хэрэгжүүлэх ажлыг уялдуулан зохион байгуулах;

13 ХАЗ-ийн гаргасан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих.

ҮЗ, ХАЗ-ИЙН ХУРАЛДСАН БАЙДАЛ



Зураг 9. ҮЗ, ХАЗ-ийн хуралдсан байдал /2017-2020/

Эх сурвалж: Монголбанк, СМА

ХАЗ-ИЙН 2017-2020 ОНД ХИЙГДСЭН ГОЛ АЖЛУУД:

2017 онд

- Монгол Улсын МУТСТ Үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 143 дугаартай тогтоолын хавсралтаар батлуулав;
- АНДМУТБ-ээс өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Засгийн газраар батлуулав;
- АНДМУТБ-ийн үнэлгээний багтай хийх газар дээрх уулзалтыг 2017 оны 5 дугаар сарын 02-ны өдрөөс 04-ний өдрүүдэд зохион байгуулав;
- ХАЗ-ийн бүрэлдэхүүнд шүүхийн байгууллагын төлөөллийг оролцуулдаг болов;
- ХАЗ-ийн ажиллах журам, бүрэлдэхүүн болон урамшууллыг шинэчлэн батлав;

2018 онд

- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд 2018 оны 4 дүгээр сарын 26-нд нэмэлт өөрчлөлт оруулж, дагалдах хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулан УИХ-аас батлуулав;
- ХАЗ-ийн дэргэд Хяналт шалгалт, Хууль сахиулах болон Хууль, эрх зүйн чиглэлээр ажиллах ажлын хэсгүүд байгуулав;
- Олон улсын байгууллагууд, яамдуудтай хамтын ажиллагаагаа эрчимжүүлж шаардлагатай салбаруудад төсөл хэрэгжүүлэн ажиллав;
- ХАЗ-ийн бүрэлдэхүүнийг өргөжүүлж, Терроризмтой тэмцэх зөвлөл болон ХАЗ-ийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх, уялдаа холбоог хангах үүднээс Хамтран ажиллах санамж бичиг байгуулав.
- Засгийн газраас 2017 онд баталсан Ажлын төлөвлөгөөний дагуу холбогдох салбаруудын эрсдэлийн үнэлгээ болон хяналт шалгалтыг хийж, журам, зааварт өөрчлөлт оруулан, шаардлагатай тохиолдолд шинээр боловсруулан, олон нийтэд таниулах, сурталчлах ажлуудыг хийж гүйцэтгэв.

2019 онд

- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль/шинэчилсэн найруулга/-ийг 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдөр батлуулав;
- ХАЗ-ийн ажиллах журамд өөрчлөлт оруулан, зөвлөлийн бүрэлдэхүүнийг өргөжүүлж Улсын дээд шүүх болон Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн бүрэлдэхүүнийг нэмж оруулав;
- ХАЗ-ийн дэргэд Судалгаа, шинжилгээний ажлын хэсгийг нэмж байгуулан ТЕГ-ын Эдийн засгийн аюулгүй байдлын Мөнгө угаахтай тэмцэх хэлтсийн даргын дор үйл ажиллагаа явуулан ажиллаж байна;
- ХАЗ-ийн дэргэд байгуулагдсан ажлын хэсгүүдэд мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулан хамтын ажиллагааг эрчимжүүлэн ажиллаж байна;
- ХАЗ-ийн гишүүн байгууллагуудын олонхийн саналаар ХАЗ-ийн дор Гадаад хамтын ажиллагааны чиглэл хариуцаж ажиллах ажлын хэсэг болон Хориг арга хэмжээг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулав.

2020 онд

- ХАЗ-ийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хүрээнд ХАЗ-ийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэсний дагуу Сангийн Яамны дэргэд Үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсэг 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн Сангийн сайдын 20 дугаартай тушаалаар байгуулагдаж, Монгол Улсын МУТС эрсдэлийг үнэлэхээр ажиллаж байна.
- МУТСТ тухай нэгдсэн мэдээллийг байршуулах, соён гэгээрүүлэх чиг үүрэг бүхий нэгдсэн цахим хуудастай болох санал ХАЗ-ийн хурлаар дэвшүүлсний дагуу www.amlcft.mn цахим хуудсыг СМА хариуцан ажиллуулахаар болов.
- ХАЗ-ийн зарим гишүүн байгууллагуудын төлөөлөл ФАТФ-ын Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлэг (ОУХАХБ)-ийн хуралд хоёр удаа оролцов. Тус хурлаар Монгол Улс нь ФАТФ-тай тохиролцсон үйл ажиллагааны төлөвлөгөөг 50% биелүүлсэн үзүүлэлттэйгээр оролцсон нь бусад улс орнуудаас эерэг сэтгэгдэл хүртэв.
- ФАТФ-ын Зөвлөмж 15: Шинэ технологид шинэчлэлт хийж ВХҮҮ-ийн зохицуулалтыг нэмсэнтэй холбогдуулан ВХҮҮ-ийн үйл ажиллагааг зохицуулах хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдав.
- Хууль сахиулах байгууллагуудын зүгээс ХАЗ-ийн хурал дээр санал гаргасны дүнд хууль сахиулах байгууллагад шаардлагатай дансны хуулгын мэдээллийг арилжааны банкууд нэг загвараар гаргаж байхаар шийдвэрлэсэн.
- 2020 оны 05 дугаар сарын 11-ний өдөр АНДХБ-тэй хийх цахим хурлыг СЯ, СМА, ТЕГ, ТТЗ, Монголбанкны бүрэлдэхүүнтэй ажлын ажлын хэсэг амжилттай зохион байгуулав.
- МУТСТ тогтолцоонд өргөн хэрэглэгддэг нэр томьёо товчлолыг шинэчлэн ХАЗ-ийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэв.

3.2

3.2.1 ФАТФ БОЛОН АНДМУТБ


ФАТФ нь МУТС болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, дэлхийн санхүүгийн системийг хамгаалах бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газар хоорондын хараат бус байгууллага юм.

ФАТФ-ЫН ГИШҮҮН ОРНУУД



1997 онд байгуулагдсан АНДМУТБ нь ФАТФ-ын төрлийн, бүс нутгийн хэмжээнд МУТСТ үйл ажиллагааг зохицуулах байгууллага бөгөөд Монгол Улс 2004 онд гишүүнээр нь элссэн билээ. ФАТФ-аас гишүүн улс орнуудын МУТСТ тогтолцоог тодорхой хугацааны давтамжтайгаар үнэлж хянадаг. Харилцан үнэлгээ нь ФАТФ-ын баталсан 40 Зөвлөмжийн дагуу Техник хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлдэг.

АЗИ, НОМХОН ДАЛАЙН МӨНГӨ УГААХТАЙ ТЭМЦЭХ БҮЛГИЙН ГИШҮҮН ОРНУУД



2017 оны 7 дугаар сараас хойш эрчимтэй хяналт болон техник туслалцааны асуудлаар Гадаад харилцааны яамны дэмжлэгтэйгээр олон улсын байгууллагуудтай нягт хамтран ажиллаж байна. АНУ, Австрали, Япон, Их Британи, Европын холбооны элчин сайдын яамд, түүнчлэн Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, Олон улсын валютын сангийн суурин төлөөлөгчийн газар, НҮБ, Олон улсын хөрөнгө оруулалтын банкны төлөөлөлтэй олон улсын хамтын ажиллагаа, техник туслалцаа авах асуудлаар болон Монгол Улсын МУТСТ тогтолцооны талаар сүүлийн үеийн мэдээлэл танилцуулах уулзалтуудыг тогтмол зохион байгуулж байна. Мөн үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох, бодлого болон хууль тогтоомжийг сайжруулах чиглэлээр СМА, Терроризмтой тэмцэх зөвлөл, Хууль зүй, дотоод хэргийн яам нь Австрали Улсын Дотоод хэргийн яамтай 2018 оны 3 дугаар сараас хамтран ажилласан.

3.2.2 ЭГМОНТ БҮЛЭГ

Дэлхийн 164 орны СМА-дын олон улсын нийгэмлэг болох Эгмонт бүлэгт Монгол Улс 2009 онд гишүүнээр элссэн. Эгмонт бүлэг нь МУТСТ зорилгоор өөрийн гишүүн орнуудын дунд туршлага, санхүүгийн мэдлэг, мэдээлэл солилцох боломжийг олгодог. Иймд СМА нь үндэсний болон олон улсын МУТС гэмт хэрэгтэй тэмцэх, хамтран ажиллах дэлхийн хэмжээний МУТСТ стандартын дагуу санхүүгийн мэдээллийг дотоод болон олон улсын хэмжээнд хуваалцах өндөр ач холбогдолтой юм.

ЭГМОНТ БАЙГУУЛЛАГЫН ГИШҮҮН ОРНУУД



3.2.3 ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ

СМА нь одоогийн байдлаар нийт 19 орны СМА-тай хоёр талын мэдээлэл солилцох харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан хамтран ажиллаж байна. Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан улс орнуудын жагсаалтыг Хавсралт 1-ээс харна уу.

3.3 ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТЕХНИК ТУСЛАЛЦАА

Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд Санхүүгийн мэдээллийн алба нь идэвхтэй ажилладаг бөгөөд Олон улсын валютын сан, Азийн хөгжлийн банк, АНУ-ын Сангийн яамны Техник туслалцааны алба болон бусад байгууллагуудтай 2017 оноос хойш хэд хэдэн техник туслалцаа, төсөл хөтөлбөрүүд дээр хамтран ажилласан. Олон улсын байгууллагуудаас авсан техник туслалцаа дараах байдлаар хэрэгжсэн бөгөөд дэлгэрэнгүйг Хавсралт 4-өөс харна уу.



ХЭРЭГЖҮҮЛСЭН ТЕХНИК ТУСЛАЛЦАА:

ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН САН

Олон улсын валютын сан нь 2017 оны 02 дугаар сараас 2019 оны 11 дүгээр сарын хооронд Монголбанкны Хяналт шалгалтын газар, Хууль, эрх зүйн газар, Санхүүгийн зохицуулах хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам, СМА-тай хамтран МУТСТ тухай хууль, эрх зүйн тогтолцоог хөгжүүлэх, Монголбанкны хяналт шалгалттай холбоотой журам, заавар, зөвлөмж, эрсдэл үнэлэх аргачлалыг боловсронгуй болгох чиглэлээр ажиллав. СМА-ны хувьд мэдээлэл технологийн чиглэлээр зөвлөгөө авах, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбоотой ФАТФ-ын стандартыг нэвтрүүлэх хүрээнд хамтран ажилласан.

Мөн СББМҮҮ-ийн хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэх, шаардлагатай хүний нөөцийг бэлдэх чиглэлээр сургалтын материал боловсруулах, Хяналт шалгалтын эрх бүхий байгууллагуудыг чадавхжуулах чиглэлээр хамтран ажиллав.

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК

2017 оны 9 дүгээр сараас эхлэн 2019 оны 11 дүгээр сарын хооронд Азийн хөгжлийн банкнаас мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд зориулан харилцагчийг таньж мэдэх журам, олон улсад мөрдөгдөж буй стандарт, хэрэгжүүлж буй арга хэмжээ, Санхүүгийн зохицуулах хорооны хяналт шалгалттай холбоотой заавар, зөвлөмж, эрсдэлийг үнэлэх аргачлалыг боловсронгуй болгох чиглэлээр СМА-тай хамтран ажиллав. Мөн мөнгөн гуйвуулга болон валют арилжааны үйл ажиллагаа эрхлэгч, үл хөдлөх хөрөнгө зуучлалын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын холбогдох албан тушаалтнууд хамтран оролцсон.

АНУ-ЫН САНГИЙН ЯАМНЫ ТЕХНИК ТУСЛАЛЦААНЫ АЛБА

СМА-ны МУТСТ чадавхыг бэхжүүлэх зорилгоор АНУ-ын Сангийн яамны Техник туслалцааны албаны зөвлөхүүд 2 сар тутамд 2 долоо хоногоор нийт 3 удаа ирж ажилласан. Үүнд:

2018 оны 01 дүгээр сард АНУ-ын Сангийн яамны техник туслалцааны хөтөлбөрийн хүрээнд зөвлөхүүдийн хийх ажил болон техник туслалцааны хүрээг тодорхойлсон. Энэхүү техник туслалцааны хүрээнд Монголбанкны Хяналт шалгалтын газар, Хууль, эрх зүйн газар, СМА, Санхүүгийн зохицуулах хороо, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Улсын ерөнхий прокурорын газар, Монголын Банкны холбоо зэрэг байгууллагууд хамтран ажиллав. Техник туслалцаа нь 2021 онд дуусахаар төлөвлөж байгаа бөгөөд 2020 онд КОВИД-19 цар тахлын улмаас зайнаас техник туслалцааг үргэлжүүлж байна.

АВСТРАЛИ УЛСЫН ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

2018 оны 3 дугаар сарын 19-23-ны өдрүүдэд Австрали Улсын Дотоод хэргийн яамнаас үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой санхүүгийн хориг арга хэмжээ авах тухай эрх зүйн зохицуулалтыг бий болгох хүрээнд бодлогын болон хууль тогтоомжийн чиглэлээр дэмжлэг үзүүлж хамтран ажиллав.

Энэ техник туслалцааны гол зорилго нь ФАТФ-ын 7 дугаар зөвлөмжтэй холбоотой эрх зүйн орчин болон бусад үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлж СМА, Терроризмтой тэмцэх зөвлөл болон Австрали Улсын Дотоод хэргийн яам хоорондын хамтын ажиллагааг сайжруулах юм. Техник туслалцааны төслийг хэрэгжүүлэхэд Монголбанкны Хяналт шалгалтын газар, СМА, Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам, Санхүүгийн зохицуулах хороо, Тагнуулын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар зэрэг байгууллагууд идэвхтэй оролцож байгаа ба КОВИД-19 цар тахлын улмаас түр зогсонги байдалд байна.

ХАМТРАН ОРОЛЦОЖ БҮЙ ТЕХНИК ТУСЛАЛЦАА:

ДЭЛХИЙН БАНК СТАР БАЙГУУЛЛАГА

Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар нь Дэлхийн банкны СТАР байгууллагатай Эрх зүйн харилцан тусалцаа болон санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа /хөрөнгө хураах, буцаан авах боловсронгуй болгох/ чиглэлээр 2018 оноос эхлэн өнөөг хүртэл техник туслалцаа хэрэгжүүлж байгаа бөгөөд СМА нь хамтран ажиллаж оролцов.

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК

Санхүүгийн зохицуулах хороо нь өөрийн зохицуулалттай мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд сэжигтэй гүйлгээг мэдээлэх, газар дээрх болон зайны хяналт шалгалтын журмыг шинэчлэн боловсруулж, бүхий л чиглэлийн хяналт шалгалтын үйл ажиллагааны зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр Олон улсын хөрөнгө оруулалтын банкны санхүүжилтээр Эрнст энд Янг аудитын компаниас техник туслалцаа авсан бөгөөд Санхүүгийн мэдээллийн албанаас журмын төслийг боловсруулахад дэмжлэг үзүүлж хамтран ажилласан. Уг техник туслалцааны эхний шат 2018 оны 01 дүгээр сараас 2018 оны 6 дугаар сарын хооронд хэрэгжсэн.

БҮЛЭГ 4

ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ, НӨӨЦ БОЛОЛЦООГ САЙЖРУУЛАХ

Өдөр бүр аливаа бүхэн өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаа энэ цаг үед МУТС-тэй холбоотой гэмт хэргүүд ч бас илүү нууцлагдмал, нарийн төвөгтэй болж байна. Иймд СМА-ны ажилтнуудад байнга хөгжиж, ур чадвараа дээшлүүлэх шаардлага зайлшгүй үүсч байна. МУТС-т үйл ажиллагааны онцлог болон цаг үеийн өөрчлөлттэй хөл нийлүүлэхийн тул СМА-ны ажилтнууд төрөл бүрийн мэргэжлийн сургалтад хамрагдаж, идэвх санаачилгатай байх зорилт тавин ажиллаж байна.

Мөн гадаад хамтын ажиллагааны хүрээнд СМА-ны ажилтнууд МУТС-чиг үүрэг бүхий олон улсын байгууллагуудын зохион байгуулсан арга хэмжээнд хамрагдаж, холбогдох стандартыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

4.1 КОМПЛАЕНС БА СУРГАЛТ

СМА-ны ажилтнууд дотоод болон гадаадын байгууллагуудын сургалт, уулзалт, семинарт тогтмол оролцож ур чадвар, мэдлэг, туршлагаа нэмэгдүүлдэг бөгөөд жил бүр МУТС-тэй холбоотой төрөл бүрийн арга хэмжээнд идэвхтэй оролцож, СМА-ны үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэхээр ажиллаж байна. Тухайлбал, хууль сахиулах байгууллагууд, арилжааны банкууд болон МУТС-чиг үүрэг бүхий бусад байгууллагуудад зориулсан дараах сургалтуудыг олон улсын байгууллагуудаас зохион байгуулахад оролцсон. Үүнд:

- АНУ-ын Сангийн яамны Техник туслалцааны алба
- Авлигатай тэмцэх газар

АНУ-ЫН САНГИЙН ЯАМНЫ ТЕХНИК ТУСЛАЛЦААНЫ АЛБА

2018 онд АНУ-ын Сангийн яамны техник туслалцааны албанаас СМА-ны ажилтнуудад зориулан “Цахим мөнгө”, “Орлогыг нотлох аргууд” болон “Оффшор банк” сэдвүүдээр сургалтууд зохион байгуулсан. АНУ-ын Сангийн яамны Техник туслалцааны албаны зөвлөх СМА-ны нийт ажилтнуудыг хамарсан сургалтыг 2018-2019 онуудад хийсэн бол 2017-2019 онуудад татвар болон гаалийн байгууллагын албан хаагчдад мөнгө угаах гэмт хэрэг, тэдгээрийг мөрдөн шалгах орчин үеийн чиг хандлагын талаар сургалт зохион байгуулав.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

Авлигатай тэмцэх газраас тогтмол олон төрлийн сургалтууд зохион байгуулдаг. Тухайлбал, 2018 онд “Оффшор бүс нутгийг ашиглан мөнгө угаах, түүнтэй тэмцэх олон улсын туршлага” ба НҮБ-ын Авлигын эсрэг конвенцын талаарх сургалтуудыг явуулсан бол 2019 онд “Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны сургалт”, “Авлигын эсрэг” болон “Монгол Улс дахь авлигын эсрэг шинэтгэл” гэх сэдвүүдээр сургалт зохион байгуулав.

СМА-ны ажилтнуудын хамрагдсан бусад дотоод сургалтын жагсаалтын дэлгэрэнгүйг Хавсралт 8-аас харна уу.

ФАТФ, АНДМУТБ, Олон улсын валютын сан, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагуудаас СМА-ны ажилтнуудыг гадаадын улс оронд зохион байгуулагдаж буй чуулга уулзалт, семинарт оролцох боломжийг олгодог. Үүний үр дүнд олон улсын хамтын ажиллагаа сайжирч, бусад улс орнуудтай мэдээлэл солилцох бололцоо нэмэгдэх ач холбогдолтой. СМА-ны ажилтнууд оролцсон сургалт, семинараас дурдвал:


- 2017 онд Малайз Улсын СМА-аас зохион байгуулсан стратеги шинжилгээний сургалтад 2017 онд СМА-ны шинжээч хамрагдсан.
- Герман Улсын Төв банкнаас 2017 оны 12 дугаар сард зохион байгуулсан МУТСТ сургалтад СМА-ны шинжээч хамрагдсан.
- Тайланд улсын Бангкок хот дахь Олон улсын хууль сахиулах академид 2017-2019 онд зохион байгуулагдсан “Санхүүгийн гэмт хэрэг мөрдөн шалгах техник” сэдэвт сургалтад СМА, хууль сахиулах байгууллагын албан хаагчид жил бүр хамрагдсан.
- 2018 онд АНУ-ын Төв банкнаас зохион байгуулсан МУТСТ сэдэвт сургалтад 2018 онд СМА-аас хянан шалгагч хамрагдав.
- Улсын ерөнхий прокурорын газраас Дэлхийн банктай “Хулгайлагдсан хөрөнгө буцаан авах санаачилга” хөтөлбөрийн хүрээнд 2018 оны 01 дүгээр сараас эхлэн хамтран ажиллаж, 2018-2019 онд СМА, хууль сахиулах байгууллага болон прокуроруудад зориулан уг сургалтыг зохион байгуулсаар байна.
- ОХУ-ын “Росфинмониторинг”-оос ОХУ-ын Москва хотод 2018 онд зохион байгуулсан “Санхүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгах боловсон хүчин бэлтгэх” сэдэвт сургалтад СМА, хууль сахиулах, хянан шалгах, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагын ажилтнууд хамрагдав.
- БНСУ-ын Пусан хотод 2018-2019 онд ФАТФ-аас зохион байгуулсан сургалтуудад Монголбанк, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, прокурорын байгууллагаас холбогдох албан тушаалтнууд оролцов.
- Монгол Улсын МУТС Үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хүрээнд 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр Дэлхийн банкнаас үзүүлж буй техник туслалцааны хүрээнд хийгдсэн цахим сургалтанд ажлын хэсгийн гишүүд буюу дотоодын эрх бүхий байгууллагуудын төлөөллүүд оролцож, СМА-аас Модуль тус бүрийг хариуцсан ажилтнууд хамрагдлаа.
- Улсын ерөнхий прокурорын газраас Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх чиглэлээр СМА-ны хянан шалгагч, Монголбанкны хянан шалгагч нар оролцож, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд хийгдэх хяналт шалгалт, зөрчлийн талаар санал зөвлөмж солилцов.
- СМА-нд мэдээлэх үүрэгтэй этгээдээс татварын гэмт хэрэгтэй холбоотой байж болзошгүй сэжигтэй гүйлгээний тайланг цөөнгүй ирүүлдэг. Ирүүлсэн сэжигтэй гүйлгээний тайлангуудад дүн шинжилгээ хийхэд тус чиглэлийн мэдлэг, туршлага ихээхэн шаардагддагийг харгалзан үзэж 2020 оны 5 дугаар сарын 28-ны өдөр Татварын ерөнхий газраас “Татварын хяналт шалгалтын үйл явц, журам түүний шинэчлэлт” гэсэн сэдвээр сургалтыг амжилттай зохион байгууллаа.

Гадаад сургалт, уулзалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 9-өөс харна уу.

4.2 СМА-ААС ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДАД ХИЙСЭН СУРГАЛТ, СЕМИНАР

МУТСТ үйл ажиллагааг боловсронгуй болгох, холбогдох байгууллагуудын ажилтнуудын чадавхыг сайжруулах зорилгоор СМА нь дангаараа болон олон улсын байгууллагуудтай хамтран сургалт, семинарыг зохион байгуулдаг.

СМА-НААС ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТ, СЕМИНАР БОЛОН ОРОЛЦОГЧДЫН ТОО /2008-2019/



Зураг 10. СМА-аас зохион байгуулсан сургалт, семинар болон оролцогчдын тоо /2008-2019/

Эх сурвалж: Монголбанк, СМА

БУСАД БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТ, СЕМИНАР БОЛОН ОРОЛЦОГЧДЫН ТОО /2008-2019/



Зураг 11. Бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалт, семинар болон оролцогчдын тоо /2008-2019/

Эх сурвалж: Монголбанк, СМА

ЭДГЭЭРЭЭС ЗАРИМ СУРГАЛТ, СЕМИНАРЫГ ДУРДВАЛ:

- Азийн хөгжлийн банктай хамтран 2017 онд Монгол Улсын хууль сахиулах байгууллага, шүүхийн байгууллагуудын мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх, шийдвэрлэх чадавхыг дээшлүүлэх, сайжруулах, чадамжийг бэхжүүлэх болон эрсдэлд суурилсан хэлбэрээр харилцагчид нарийвчилсан дүн шинжилгээ хийх талаар хамтарсан сургалт зохион байгуулж хөтөлбөрийг амжилттай дуусгав.

- Азийн хөгжлийн банктай хамтран 2017-2018 онуудад хянан шалгагчид, банк, банкнаас бусад санхүүгийн байгууллага, валют арилжаа болон үл хөдлөх хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын ажилтнуудад зориулсан Харилцагчийг таньж мэдэх (ХТМ), урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам болон олон улсад мөрдөгдөж буй стандарт, хэрэгжүүлж буй арга хэмжээ сэдэвт сургалтыг зохион байгуулав.

- Монголбанкны Хяналт шалгалтын газрын Тусгай хяналтын алба, Банк санхүүгийн академи болон бусад байгууллагаас 2018 онд зохион байгуулсан 4 удаагийн сургалтаар МУТСТ тухай сэдвээр 30 орчим цагийн сургалтыг 2018 онд хийсэн.
- Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын стратегийг олон нийтэд ил болгох, танилцуулах зорилгоор Монголын Банкны Холбоо болон Комплаенсийн мэргэжлийн зөвлөлийн зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлэгт илтгэл тавьж, панелистээр оролцсон. Түүнчлэн Монголбанкны банкны системийн эрсдэлийн хэлэлцүүлгийг Монголын Банкны Холбоо болон арилжааны банкуудыг оролцуулан зохион байгуулсан. “Эрсдэлд суурилсан зарчмыг банкны үйл ажиллагаанд хэрэгжүүлэх зөвлөмж”-ийг боловсруулан батлуулж, англи, монгол хэлээр Монголбанкны цахим хуудсанд байршуулсан.
- Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Банкны Холбоо, арилжааны банк, банкнаас бусад санхүүгийн байгууллага, СББМҮҮ нарт хууль тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлтийг танилцуулах, МУТСТ олон улсын стандартыг таниулах, олон улсын туршлага судлах, холбогдох байгууллагуудын ажлын уялдааг сайжруулах чиглэлээр сургалт, семинар тогтмол зохион байгуулж, албан хаагчдыг мэргэшүүлэхэд анхааран ажиллав.
- 2018-2019 онд Австрали Улсын Дотоод хэргийн яамнаас үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх болон хориг арга хэмжээ хэрэгжүүлэх чиглэлээр техник туслалцаа авч, холбогдох төрийн байгууллагууд, хууль сахиулах байгууллагууд болон гаалийн байгууллагын албан тушаалтнуудад зориулсан сургалт зохион байгуулав.
- Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Улсын ерөнхий прокурорын газартай хамтран “Эдийн засгийн гэмт хэрэг болон мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгаж, шийдвэрлэхэд прокурорын чадавхыг бэхжүүлэх нь” сэдвээр 2018 оны 01 дүгээр сараас эхлэн хамтран төсөл хэрэгжүүлж байна.
- НҮБ-ын Терроризмтой тэмцэх албатай хамтран терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх албан хаагчдын чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр 2018-2019 онд “Террорист этгээдийн жагсаалтыг мөрдөж ажиллах болон хөрөнгө царцаах тогтолцоо” сэдэвт үргэлжилсэн сургалтууд зохион байгуулж хамтран ажиллав.
- НҮБ-ын Мансууруулах бодис, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх албатай хамтран 2019 оны 9 дүгээр сарын 17-19-ний өдрүүдэд “Терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхтэй тэмцэх” сэдэвт бүсийн хурлыг Улаанбаатар хотод зохион байгуулав. Хурлаар НҮБ-ын терроризмын санхүүжүүлэлт болон үй олноор хөнөөх зэвсэгтэй тэмцэх тогтолцоо, холбогдох олон улсын стандарт, НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан Исламын улсын эсрэг хориг арга хэмжээний тогтоолууд, үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэх үйл ажиллагааны санхүүжилттэй тэмцэх тогтолцоо болон холбогдох хөрөнгийн царцаалт зэрэг сэдвээр илтгэл тавигдсан бөгөөд манай улсаас Монголбанк, СМА, Санхүүгийн зохицуулах хороо, Улсын ерөнхий прокурорын газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам, Терроризмтой тэмцэх зөвлөл, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газраас төлөөлөл оролцож, дээрх сэдвүүдийн хүрээнд өөрийн орны талаарх мэдээллийг өгч оролцлоо.
- СМА нь МУТСТ чиглэлээр “СМА-ны үүрэг, оролцоо болон төрийн бусад байгууллагуудтай хийх хамтын ажиллагаа” гэсэн сэдвийн хүрээнд соён гэгээрүүлэх ажлыг хийдэг. СМА-аас соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулахдаа СМА-ны нөөц, бололцоонд тулгуурлан нэн тэргүүнд шаардлагатай байгууллагуудыг сонгон авч, үйл ажиллагааны түвшинд ажилладаг ажилтнуудад таниулах хэлбэрээр сургалтыг зохион байгуулдаг.
- СМА-аас төрийн эрх бүхий байгууллагууд болох Авлигатай тэмцэх газар, Гаалийн ерөнхий газар, Санхүүгийн зохицуулах хороо, Цагдаагийн ерөнхий газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар болон өөрийгөө зохицуулах байгууллагууд болох Монголын Нотариатчдын танхим, Монголын Хуульчдын холбоо зэрэг байгууллагуудад чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг хийж гүйцэтгэсээр ирсэн. 2018-2019 онуудад хийгдсэн соён гэгээрүүлэх ажлаас гарсан үр дүнг Хавсралт 3-аас харна уу.
- Мөн СББМҮҮ-дэд хийсэн сургалт, семинар, форум, хэлэлцүүлэг, уулзалтын мэдээг Хавсралт 5-аас харна уу.

БҮЛЭГ 5

ТИПОЛОГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ КЕЙС

Энэхүү бүлэгт типологийн¹ кейсүүдээс хүргэж байна.

5.1 ТИПОЛОГИ 1

МЭРГЭЖЛИЙН МӨНГӨ УГААХ ҮЙЛЧИЛГЭЭ

Зохион байгуулалттай гэмт хэргийн бүлгээс эхлээд хувь хүн хүртэл гэмт хэргээс олсон орлогыг угаах зорилгоор санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийг² ашиглаж гэмт хэргээс олсон орлогыг цэвэршүүлэх, санхүүгийн системд хууль ёсны мэт харагдуулах үйл ажиллагааг хийдэг. Эдгээр үйлчилгээ үзүүлэгчид нь гэмт хэргээс олсон орлого гэдгийг мэддэг бөгөөд цаашид яаж хөдөлгөх, хаашаа шилжүүлэхийг мэргэжлийн түвшинд хийж, гэмт этгээд болон гэмт хэргээс олсон орлогын холбоог нуун далдлах үүргийг гүйцэтгэдэг. Учир нь гэмт хэргийн орлогыг бүрдүүлэгч этгээд нь хууль сахиулах байгууллагын хяналтаас гадуур мөнгийг цэвэршүүлэх мэдлэггүй байдаг. Эцсийн дүнд санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч нь гэмт хэрэгтэн болох ба их дүнтэйгээр, илрүүлэхэд маш төвөгтэй схемийг бүрдүүлж мөнгө угаах гэмт хэргийг улам мэргэжлийн хэмжээнд гүйцэтгэж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд бэрхшээлтэй байдлыг бий болгодог. Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч нь мөнгө угаах үйл ажиллагааны хажуугаар ихэвчлэн дараах мэргэжлийн үйлчилгээг үзүүлдэг. Үүнд:

- Нягтлан бодогч, хуульч, нотариатч болон бусад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч;
- Траст болон компанитай холбоотой үйлчилгээ үзүүлэгч;
- Банкир;
- Мөнгө эсхүл үнэ бүхий зүйлийг шилжүүлэх үйлчилгээ үзүүлэгч;
- Брокер;
- Төсвийн мэргэжилтэн эсхүл татварын асуудал хариуцсан зөвлөх үйлчилгээ үзүүлэгч;
- Үнэт металл, чулуу арилжаалагч этгээд;
- Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага;
- Банкны өмчлөгч, эсхүл дотоод ажилтан;
- Төлбөр тооцоог гүйцэтгэгч, түүнийг эзэмшигч эсхүл дотоод ажилтан;
- Электрон болон криптовалют арилжаалагч, түүний эзэмшигч эсхүл дотоод ажилтан.

¹ Типологи гэдэг нь судалгаанд ашиглагдах боломжтой бүлэглэж, ангилсан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн арга хэлбэрүүд юм.

² Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч нь суурь гэмт хэргийн орлогыг олоход ямар нэгэн оролцоогүй байх боломжтой боловч хууль бус орлогоос олсон мөнгийг угааж, тодорхой хувийн шимтгэл авч ажилладаг байна. Мэргэжлийн мөнгө угаах үйлчилгээ үзүүлэхийн хажуугаар бусад хууль ёсны үйл ажиллагааг эрхэлдэг онцлогтой.

Бохир мөнгө эдгээр мэргэжлийн оролцогч дээр ирэхдээ хэд хэдэн хувь хүн, хуулийн этгээдийг дамжин олон арга замаар ирдэг.

МЭРГЭЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ЗАГВАР

Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч нь мөнгө угаах үйл ажиллагааны бүх шатанд (байршуулах, тараах, гүйлгээнд оруулах) хөрөнгийг удирдах, цуглуулах, хөдөлгөөнд оруулах байдлаар оролцох боломжтой. Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч үйлчлүүлж буй этгээдийн нөхцөл байдалд таарсан, илрүүлэхэд нарийн төвөгтэй, схемийг бүрдүүлэх байдлаар мэргэжлийн түвшинд үйлчилгээ үзүүлж мөнгийг угаадаг байна.

Мэргэжлийн үйлчилгээг дараах байдлаар үзүүлдэг. Үүнд:

- Зөвлөх, зөвлөгөө өгөх, зөвлөлдөх;
- Компани эсхүл дансыг өөрийн нэр дээр бүртгүүлэх үйлчилгээ;
- Хуурамч бичиг баримтаар хангах;
- Хууль ёсны болон хууль бус орлогыг нийлүүлэх;
- Хууль бус бэлэн мөнгийг байршуулах, хөдөлгөх;
- Хөрөнгө худалдан авах;
- Санхүүжилт авах;
- Хөрөнгө оруулах боломжуудыг гаргаж өгөх;
- Шууд бусаар хөрөнгө худалдаж авах, эзэмших;
- Мөнгө тээвэрлэгч этгээдийг элсүүлэх, зохион байгуулах;
- Шүүхийн ажиллагаанд нөлөөлөх, удирдах.

Мөнгө угаах мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн ашигладаг нийтлэг схем:

1. Худалдааны санхүүжилт;
2. Нууц болон альтернатив банкны платформ;
3. Мөнгө болон үнэ бүхий зүйл шилжүүлэгч этгээд;
4. Банк санхүүгийн байгууллагууд;
5. Хуулийн болон мэргэжлийн үйлчилгээ;
6. Төлбөр, тооцоо гүйцэтгэдэг компани.

5.2 ТИПОЛОГИ 2

МӨНГӨН ГУЙВУУЛГА БОЛОН ВАЛЮТ АРИЛЖААНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

МУТС-д мөнгөн гуйвуулга болон валют арилжааны үйлчилгээг 2 янзаар ашигладаг байна. Үүнд хууль бус орлого гэдгийг болон зориулалтыг нь мэдэхгүйгээр үйлчилгээ үзүүлэх, мөн тухайн байгууллагын ажилтан, удирдлагыг оролцуулан хууль бус үйлдлийг гүйцэлдүүлэх замаар мөнгө угаадаг. Мөнгөн гуйвуулга, валют арилжааны үйлчилгээг дараах замаар буруугаар ашигласаар байна. Үүнд:

- Нууц буюу далд гуйвуулгын үйлчилгээг ашиглах;
- Мөнгөний гарал үүсэл, гуйвуулга хийж буй хүн болон хүлээн авч буй хүний мэдээллийг зөрүүлэх;
- Хэсэг бүлэг этгээд тодорхой хугацааны давтамжтайгаар нэг этгээд эсхүл холбоотой этгээдүүдэд мөнгөн гуйвуулга хийх;
- Богино хугацаанд олон жижиг гуйвуулгаар их хэмжээний мөнгө шилжүүлэх;
- Гэнэт их хэмжээний бэлэн мөнгө орж ирэх, их хэмжээний мөнгө гарах;
- ХТМ-тэй холбоотой баримт материалыг хуурамчаар үйлдэх.

Ихэнх тохиолдолд маш олон жижиг гуйвуулга хийгдсэн байх ба нийлбэр дүнгээр ач холбогдол бүхий мөнгөн хөрөнгийг шилжүүлсэн байдаг. Ийм байдлаар нарийн төвөгтэй, зохион байгуулалттайгаар мөнгө угаах үйл ажиллагааг хийж байна.

БҮЛЭГ 6


МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН БҮТЭЦ

6.1 СМА-НЫ ДОТООД МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН БҮТЭЦ

2019 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Монголбанкны Ерөнхийлөгчийн А-326 дугаар тушаалын хавсралтаар Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журмыг баталсан. Энэхүү журмын дагуу мэдээлэх үүрэгтэй этгээд нь СГТ, БМГТ, ГТГТ болон нэмэлт мэдээллүүдийг СМА-д ирүүлдэг.

СМА-д ирүүлэх тайлан нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:


Зураг 12. СМА-нд ирүүлэх тайлангийн шаардлага



Эх сурвалж: СМА-д мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам

СМА-д мэдээлэх үүрэгтэй этгээд нь сэжигтэй гүйлгээний тайлангаа мэдээллийн санд ирүүлсний дараагаар ахлах шинжээчид эрсдэлийн матрицийн аргаар үнэлэн өндөр оноо авсан гүйлгээг шинжээчдэд хуваарилан өгнө. Үүний дараагаар шинжээчид сэжигтэй гүйлгээний тайланд дүн шинжилгээ хийх явцдаа холбогдох байгууллагуудаас нэмэлт мэдээлэл авч шинжилгээ хийдэг.

Зураг 13. СМА-ны дотоод мэдээллийн системийн бүтэц



Эх сурвалж: Монголбанк, СМА

Одоогийн байдлаар банкууд хуульд заасан тайлан, мэдээллийг онлайнаар, банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээд нь эксэл файлаар дамжуулан цахим хэлбэрээр СМА-д мэдээлж байна. Үүнтэй холбоотойгоор СМА-ны үйл ажиллагаанд ашиглаж буй программ хангамжийг сайжруулах шаардлага тулгарсан.

6.2 СМА-НЫ ПРОГРАММ ХАНГАМЖ

Дэлхийн аль ч орны СМА-ны хувьд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй үр дүнтэй тэмцэх, хууль тогтоомжид заасан үүргээ өндөр чадавхтай хэрэгжүүлэхэд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд зориулж тусгайлан хөгжүүлсэн программ хангамж ашиглах явдал чухал байдаг.


СМА-ны одоо ашиглаж байгаа программ нь МУТСТ тухай хуульд заасан бүх мэдээлэх үүрэгтэй этгээдээс 3 төрлийн тайланг онлайнаар хүлээн авах боломжгүй, олон төрлийн өөр форматтай мэдээллийг зөв зохистой удирдан нэгтгэж, дүн шинжилгээ хийх, нарийвчилсан хайлт хийх, бүртгэл хөтлөх, дэлгэрэнгүй статистик мэдээ гаргах, мэдээллийн хэлбэлзэл, давтамж, хоорондын холбоо хамаарал, зүй тогтлыг илрүүлж, график, дүрслэлээр үзүүлэх, жагсаалтууд үүсгэж мэдээллийн сан дахь мэдээлэлтэй харьцуулан тулгаж шалгах гэх мэт үндсэн болон бусад нэмэлт үйлдэл хийх чадамж сул байна.

Тиймээс бид улс орнуудын өргөн хэрэглэдэг GoAML программ хангамжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ашиглахаар ажиллаж байна.

6.3 GOAML ПРОГРАММ ХАНГАМЖИЙН ТУХАЙ

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас улс орнуудын МУТСТ чадавхыг ахиулах, МУТСТ үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэх үүднээс GoAML хэрэглээний программыг СМА-дад тусгайлан зориулж боловсруулжээ. Энэхүү GoAML программ нь мэдээлэл цуглуулах, дүрэмд суурилсан дүн шинжилгээ хийх, эрсдэлийг үнэлэх, хууль сахиулах байгууллагуудад чиглэл өгөх, мэдээллийг түргэн шуурхай хүргүүлэх зориулалттай юм. Өдгөө GoAML программыг Мексик, Шинэ Зеланд, Ирланд, Люксембург, Балба зэрэг дэлхийн 50 гаруй улс оронд ашиглаж байгаа бөгөөд эрэлт нь өдрөөс өдөрт нэмэгдэж байна. Өнөөдрийн байдлаар GoAML-тэй өрсөлдөх ижил төстэй программ хангамж дэлхий нийтэд гараагүй байна. GoAML программ хангамжийн гол онцлог нь өгөгдөл цуглуулах бүрэлдэхүүн хэсэг нь мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд мэдээ, тайланг (СГТ, БМГТ, ГТГТ) цахим хэлбэрээр хүргүүлэх боломжийг олгодог юм. Тайланг оффлайн (XML өгөгдлийн солилцоо, тухайлбал цахим шуудангийн хавсралт, CD, хатуу зөөврийн диск зэрэг), онлайн (XML өгөгдлийн мессежийг шууд ачааллах замаар) эсвэл СМА-ны цахим хуудсанд байршуулсан онлайн маягт бөглөх, илгээх хэлбэрээр хүргүүлж болно.

Зураг 14. GoAML программ хангамжийн үйлдлүүд



6.4 БУСАД

Монгол Улсын МУТСТ тогтолцоотой холбоотой мэдээ мэдээллийг олон нийтэд ойлгомжтой, ил тод хүргэх үүднээс www.amlcft.mn болон <https://fiu.mongolbank.mn/> гэсэн хоёр үндсэн цахим хуудсаар дамжуулан хүргэж байна.

www.amlcft.mn цахим хуудас нь Монгол Улсын болон олон улсын МУТСТ, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, арга хэмжээний талаарх цаг үеийн мэдээлэл, зөвлөмж, сэрэмжлүүлэг, мөрдөгдөж буй хууль, эрх зүйн акт, хориг арга хэмжээ болон бусад мэдээллийг агуулсан мэдээллийн нэгдсэн систем юм. Энэхүү цахим хуудсыг ФАТФ-ын стандартын Шууд хэрэгжилт 11-ийг хангах чиг үүрэг бүхий ажлын хэсэг БНХАУ-ын Бээжин хотод хамгаалсан тайлангийн үеэр ашигласан бөгөөд МУТСТ ажлын хүрээнд зарим ажлыг хөнгөвчилж, ФАТФ-аас тавьсан зарим шаардлагуудын хэрэгжилтийг хангахад дэмжлэг болсон.

<https://fiu.mongolbank.mn/> цахим хуудаст МУТСТ ажлын талаарх мэдээлэл болон СМА-ны үйл ажиллагаатай холбоотой нийтлэл, мэдээллийг цаг тухай бүрт нь байршуулан ажиллаж байна.

БҮЛЭГ 7

ҮНДЭСНИЙ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

МУТС Үндэсний эрсдэлийн үнэлгээний зорилго нь Монгол Улсын МУТС эрсдэлийг ойлгох, хууль сахиулах, зохицуулах, урьдчилан сэргийлэх байгууллагуудын хязгаарлагдмал нөөцийг үр дүнтэй хуваарилах, оновчтой арга хэмжээ авч хэрэгжүүлэх замаар тус эрсдэлийг бууруулахад оршино. Энэхүү зорилгын хүрээнд эрсдэлд суурилсан хэлбэрээр авах арга хэмжээний стратеги, төлөвлөгөө боловсруулахын тулд Үндэсний эрсдэлийн үнэлгээний тайланг боловсруулдаг. МУТС эрсдэлийн талаар ойлголт, мэдлэгтэй байх нь Засгийн газар, хууль сахиулах, хяналт тавих, зохицуулах чиг үүрэг бүхий байгууллагуудад энэхүү гэмт хэрэгтэй тэмцэхэд, ялангуяа гэмт хэргийн өндөр эрсдэлтэй салбар, газар зүйд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах, нөөцийг үр дүнтэй хуваарилах, бодлого боловсруулахад дөхөмтэй байх болно. ФАТФ-аас гаргасан МУТСТ олон улсын стандартын дагуу улс орнууд Үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх үүрэгтэй. Монгол Улс ФАТФ-ын төрлийн бүс нутаг хариуцсан байгууллага болох АНДМУТБ-т гишүүнчлэлээрээ дамжуулж уг стандартыг хэрэгжүүлэх бүрэн хүсэл эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлсэн.


Үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг СМА зохион байгуулан ажилладаг ба Монгол Улсын анхны МУТС Үндэсний эрсдэлийн үнэлгээг 2016 онд хийсэн. Энэхүү Үндэсний эрсдэлийн үнэлгээгээр МУТС гэмт хэрэг, банкны салбар, банкнаас бусад санхүүгийн салбар, СББМҮҮ-ийн салбарын эрсдэлийн үнэлгээг хийсэн.

Хоёр дахь удаагийн Үндэсний эрсдэлийн үнэлгээг энэ онд буюу 2020 онд багтаан хийхээр болж 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр Сангийн сайдын 20 дугаартай тушаалын хавсралтаар Монгол Улсын МУТС Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийж тайлагнах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн

бүрэлдэхүүнийг баталлаа. Энэ хүрээнд Сангийн сайдын 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 90 дугаартай тушаалын хавсралтаар дараах Дэд ажлын хэсгүүдийг байгуулсан. Үүнд:

1. Мөнгө угаах аюул заналхийллийг үнэлэх дэд ажлын хэсэг
2. Үндэсний эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг
3. Банкны салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг
4. Үнэт цаасны салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг
5. Даатгалын салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг
6. Банкны бус санхүүгийн байгууллагын салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг
7. СББМҮҮ-дийн салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг
8. Терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх дэд ажлын хэсэг
9. Санхүүгийн хүртээмжтэй бүтээгдэхүүний эрсдэлийг үнэлэх дэд ажлын хэсэг
10. Ашгийн бус байгууллагын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг

Үүнийг бүдүүвч зургаар харуулбал:



Үндэсний эрсдэлийн үнэлгээгээр бүх салбарууд дахь бодитой эрсдэлүүдийг тодорхойлсны үндсэн дээр илэрсэн эрсдэлүүдийг бууруулах зорилгоор үндэсний стратеги, хөтөлбөрийг боловсруулдаг. Үүний дараа холбогдох байгууллагууд хамтран үндэсний хөтөлбөрт тусгагдсан ажлуудыг хийж гүйцэтгэн, ФАТФ-ын зөвлөмжүүдийн шаардлагыг хангах тал дээр бэлтгэл ажлыг хангаж, Харилцан үнэлгээний тайланг бэлддэг.

БҮЛЭГ 8

АНДМУТБ ХАРИЛЦАН ҮНЭЛГЭЭ БОЛОН ОУХАХБ-ЫН ДҮГНЭЛТ

8.1

АНДМУТБ-ИЙН МӨНГӨ УГААХ ТОГТОЛЦООГ ҮНЭЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ХАРИЛЦАН ҮНЭЛГЭЭ

8.1.1. АНДМУТБ-ИЙН МОНГОЛ УЛСАД ХИЙСЭН ХАРИЛЦАН ҮНЭЛГЭЭ

Монгол Улс 2004 онд ФАТФ-ын төрлийн бүс нутаг хариуцсан байгууллага болох АНДМУТБ-ийн гишүүн улс болж, улмаар 2006 оны 7 дугаар сард Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг баталсан.

АНДМУТБ-ээс Монгол Улсын МУТСТ тогтолцоонд 2007 онд анхны харилцан үнэлгээг, 2017 онд хоёр дахь харилцан үнэлгээг хийсэн. Монгол Улсад 2007 онд хийгдсэн анхны харилцан үнэлгээгээр ФАТФ-ын 49 зөвлөмж³-өөс 21 зөвлөмжийг “Биелүүлээгүй”, 15 зөвлөмжийг “Хэсэгчлэн биелүүлсэн” гэх үнэлгээг авч байв.

Энэ үр дүнгээс шалтгаалан 2011 оны 6 дугаар сард ФАТФ-аас Монгол Улсыг МУТСТ стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтад оруулсан. Мөн үүний дараа 2013 оны 10 дугаар сард ФАТФ-аас Монгол Улсыг ажлын төлөвлөгөөнд багтсан ихэнх чухал ажлуудыг “Биелүүлээгүй” гэж үзэн хангалтгүй ахиц үзүүлж буй улс орнуудын жагсаалтад оруулсан. Тухайн үед Монгол Улсын эдийн засгийн өсөлт өндөр, гадаад нэр хүнд сайн байсан зэргээс шалтгаалан эдийн засагт учруулсан бодит

³ ФАТФ-аас анх мөнгө угаахтай тэмцэх олон улсын стандартыг гаргахдаа 40+9 байдлаар гаргаж байсан. Улмаар 2012 онд Техник хэрэгжилтийн 40, Шууд хэрэгжилтийн 11 үзүүлэлт болгон шинэчилсэн.

хохирол бага байв. Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас шуурхай арга хэмжээ авч Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Эрүүгийн хуульд шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг оруулан холбогдох журам, зааврыг богино хугацаанд батлуулсны үр дүнд Техник хэрэгжилтийн тайланг дахин үнэлж, Монгол Улсыг 2014 оны 6 дугаар сард МУТСТ стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтаас гаргасан.

Үүнээс хойш 2017 онд хоёр дахь удаагийн Харилцан үнэлгээг хийж, үнэлгээнд Монгол Улсын нөхцөл байдлыг 2016 оны 11 дүгээр сарын байдлаар тасалбар болгон хамруулсан бөгөөд ФАТФ-ын Техник хэрэгжилтийн 40 зөвлөмжөөс гадна Үр дүнтэй байдлын 11 Шууд хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийн дагуу шалгасан нь энэхүү хоёр дахь удаагийн Харилцан үнэлгээний онцлог байв.

Монгол Улс 2016 оны 6 дугаар сард Техник хэрэгжилтийн тайланг, 2016 оны 9 дүгээр сард Үр дүнтэй байдлын тайланг тус тус үнэлгээний багт хүргүүлж, үнэлгээний баг газар дээрх уулзалт, шалгалтыг хийхээр 2016 оны 10 дугаар сар болон 2017 оны 5 дугаар сард тус тус Монгол Улсад айлчлан, холбогдох байгууллагуудтай уулзалт хийж, тайланг нягтлан баталгаажуулсан.

Шри Ланка Улсын Коломбо хотод 2017 оны 7 дугаар сард зохион байгуулагдсан АНДМУТБ-ын ээлжит хурлаар Монгол Улсын Харилцан үнэлгээний тайланг хэлэлцэж, Монгол Улсыг “Өргөтгөсөн эрчимтэй хяналт”-д оруулж, ФАТФ-ын “МУТСТ стратегийн дутагдалтай орнуудын жагсаалт”-д орох эрсдэлтэй байгаа тул хугацаатай үүрэг даалгавар өгсөн бөгөөд улмаар МУТСТ стратегийн дутагдалтай улсын жагсаалтад оруулан нийтэд зарлах арга хэмжээ авахыг хойшлуулж Монгол Улсад хугацаа өгсөн.

“Өргөтгөсөн эрчимтэй хяналт”-д оруулах нөхцөл нь:

- ФАТФ-ын 40 зөвлөмжийн Техник хэрэгжилтийн үнэлгээнд 20 болон түүнээс дээш зөвлөмжид “Биелүүлээгүй” эсхүл “Хэсэгчлэн биелүүлсэн” гэх үнэлгээг авсан бол;
- Зөвлөмж 3,5,6,10,11 болон 20-иос 3 болон түүнээс зөвлөмжид “Биелүүлээгүй” эсхүл “Хэсэгчлэн биелүүлсэн” гэх үнэлгээг авсан бол;
- ФАТФ-ын 11 Шууд хэрэгжилтийн 9 болон түүнээс дээшид “Доогуур” эсхүл “Дунд зэрэг” гэх үнэлгээг авсан, түүнээс хамгийн багадаа 2-т нь “Доогуур” үнэлгээ авсан бол;
- ФАТФ-ын 11 Шууд хэрэгжилтийн 6 болон түүнээс дээшид “Доогуур” үнэлгээг авсан тохиолдолд хамаарах бөгөөд дээрх үнэлгээг авсан улс орныг МУТСТ тогтолцоо, түүний хэрэгжилтийг ноцтой дутагдалтай гэж дүгнэн хяналтад оруулдаг байна.

2017 оны Харилцан үнэлгээгээр Монгол Улсын МУТСТ тогтолцооны Техник хэрэгжилтийг ФАТФ-ын 40 зөвлөмжөөс 5 зөвлөмжид “Бүрэн биелүүлсэн” /C-5/, 15 зөвлөмжид “Дийлэнхийг биелүүлсэн” /LC-15/, 15 зөвлөмжид “Хэсэгчлэн биелүүлсэн” /PC-15/, 5 зөвлөмжид “Биелүүлээгүй” /NC-5/ гэж үнэлэв. Харин Үр дүнтэй байдал буюу Шууд хэрэгжилтийн 11 үзүүлэлтээс 2 үзүүлэлтийг “Дунд зэрэг” хэрэгжилттэй, 9 үзүүлэлтийг хэрэгжилт “Муу” буюу бүхэлдээ хангалтгүй гэж үнэлэв.

Хүснэгт 3. Техник хэрэгжилтийн үнэлгээний үр дүн – 2017 он

/Бүрэн биелүүлсэн: C-compliant, Дийлэнхийг биелүүлсэн: LC-largely compliant, Хэсэгчлэн биелүүлсэн: PC-partially compliant, Биелүүлээгүй: NC-noncompliant/

Зөвлөмж 1	Зөвлөмж 2	Зөвлөмж 3	Зөвлөмж 4	Зөвлөмж 5	Зөвлөмж 6	Зөвлөмж 7	Зөвлөмж 8
PC	PC	LC	LC	LC	PC	NC	PC
Зөвлөмж 9	Зөвлөмж 10	Зөвлөмж 11	Зөвлөмж 12	Зөвлөмж 13	Зөвлөмж 14	Зөвлөмж 15	Зөвлөмж 16
LC	LC	C	LC	LC	PC	LC	LC
Зөвлөмж 17	Зөвлөмж 18	Зөвлөмж 19	Зөвлөмж 20	Зөвлөмж 21	Зөвлөмж 22	Зөвлөмж 23	Зөвлөмж 24
NC	LC	PC	LC	PC	NC	NC	PC
Зөвлөмж 25	Зөвлөмж 26	Зөвлөмж 27	Зөвлөмж 28	Зөвлөмж 29	Зөвлөмж 30	Зөвлөмж 31	Зөвлөмж 32
PC	PC	LC	NC	PC	C	C	PC
Зөвлөмж 33	Зөвлөмж 34	Зөвлөмж 35	Зөвлөмж 36	Зөвлөмж 37	Зөвлөмж 38	Зөвлөмж 39	Зөвлөмж 40
PC	PC	PC	C	C	LC	LC	LC

Эх сурвалж: Харилцан үнэлгээний тайлан, 2017

Хүснэгт 4. Үр дүнтэй байдлын үнэлгээний үр дүн – 2017 он

/High – Хэрэгжилт сайн, Substantial – Ихэнх нь хэрэгждэг, Moderate – Дунд зэргийн хэрэгжилттэй, Low – Хэрэгжилт муу/

Шууд хэрэгжилт 1	Шууд хэрэгжилт 2	Шууд хэрэгжилт 3	Шууд хэрэгжилт 4
Low	Moderate	Low	Low
Шууд хэрэгжилт 5	Шууд хэрэгжилт 6	Шууд хэрэгжилт 7	Шууд хэрэгжилт 8
Low	Low	Low	Moderate
Шууд хэрэгжилт 9	Шууд хэрэгжилт 10	Шууд хэрэгжилт 11	
Low	Low	Low	

Эх сурвалж: Харилцан үнэлгээний тайлан, 2017

Монгол Улс нэн тэргүүнд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль эрх зүйн орчноо сайжруулах, улмаар Харилцан үнэлгээний тайлангаар хангалтгүй үнэлгээ авсан Техник хэрэгжилтийн зөвлөмж, Шууд хэрэгжилтийн үзүүлэлтүүдийг хангаж ажиллах үүрэг хүлээсэн юм.

8.1.2. ХАРИЛЦАН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮНГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛГООР 2017-2019 ОНУУДАД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Монгол Улсын МУТСТ тогтолцоог сайжруулах зорилгоор Монголбанкнаас санаачлан холбогдох байгууллагуудтай хамтран дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 143 дугаар тогтоолын хавсралтаар Монгол Улсын МУТСТ Дунд хугацааны үндэсний хөтөлбөрийг батлав.
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс 2017 онд зөвлөмж гаргаж, биелэлтийг зохион байгуулж ажиллав.
- ХАЗ-ийн бүрэлдэхүүнийг өргөжүүлж, тодорхой чиглэлийн ажлын хэсгүүдийг ХАЗ-ийн дэргэд байгуулах зэргээр үйл ажиллагааг эрчимжүүлэв.
- Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018, 2019 онуудад баримтлах үндсэн чиглэлд холбогдох асуудлыг тусган хэрэгжүүлж ажиллав.
- “АНДМУТБ-ээс өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г боловсруулан, Монгол Улсын Засгийн газраар батлуулж, биелэлтийг хангаж ажиллав.
- Холбогдох хууль тогтоомжид оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулах, батлуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгүүдэд ажиллаж, батлуулав.

Тухайлбал:

- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль;
- Эрүүгийн хууль;
- Терроризмтой тэмцэх тухай хууль;
- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль;
- Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль;
- Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Тагнуулын байгууллагын тухай хууль;
- Зөрчлийн тухай хууль;
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль;
- Гаалийн тухай хууль;
- Шуудангийн тухай хууль;
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль;
- Банкны тухай хууль;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам;

- Террорист этгээдийн жагсаалтад оруулах, жагсаалтад орсон этгээдийн хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох, хянах журам;
- Бусад хууль, тогтоомжууд.

Тухайлбал 2017 онд хийгдсэн Харилцан үнэлгээний тайланд Монгол Улсын СББМҮҮ болох хуульч, нотариатч, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч мэргэжлийн байгууллагуудын МУТСТ талаар ойлголт сул, хяналт шалгалтыг хийдэггүй, тэдний МУТСТ талаарх эрсдэлийг үнэлдэггүй, хяналт шалгалт хийх байгууллага тодорхойгүй гэх зэрэг асуудлуудыг хөндсөн.

Энэ ажлын хүрээнд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр нотариатч, хуульч, эсхүл нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нарыг тодорхой үйл ажиллагааг явуулсан тохиолдолд СМА-д мэдээлэхээр тусгасан. Мөн СББМҮҮ-д хүрч ажиллах ажлын хүрээнд СМА нь МУТСТ тухай болон эрсдэлийн үнэлгээний талаарх сургалтуудыг Санхүүгийн зохицуулах хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институттэй хамтран хийсэн. Сургалтын дэлгэрэнгүйг Хавсралт 5-аас харна уу.

8.1.3. ҮЗҮҮЛСЭН АХИЦ ДЭВШЛЭЭС ҮҮДЭН ҮНЭЛГЭЭГ АХИУЛАХ НЬ

Дээр дурдсанчлан 2017 оны 7 дугаар сард Монгол Улсыг “Өргөтгөсөн эрчимтэй хяналт”-д оруулж, хугацаатай үүрэг даалгавар өгсөнтэй холбогдуулан Харилцан үнэлгээгээр хангалтгүй үнэлгээ авсан Техник хэрэгжилтийн 20 зөвлөмжийн үнэлгээг ахиулах хүсэлтийг Монгол Улс 2019 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр гарган, техник хэрэгжилтийн зөвлөмжийн биелэлтийн тайланг дагалдах баримт бичгийн хамт АНДМУТБ-т хүргүүлсэн. Энэхүү тайланг 2019 оны 8 дугаар сард болсон АНДМУТБ-ийн жилийн ээлжит хурлаар хэлэлцэн, Харилцан үнэлгээгээр хангалтгүй үнэлгээ авсан нийт 20 зөвлөмжөөс 16 зөвлөмжийн үнэлгээг ахиулж, 2019 оны 10 дугаар сарын байдлаар Монгол Улс ФАТФ-ын 40 Зөвлөмжийн 35-ийг хангалттай хэмжээнд биелүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 5. Харилцан үнэлгээний тайлангаар хангалтгүй үнэлгээ авсан Техник хэрэгжилтийн үнэлгээг ахиулсан
/Бүрэн биелүүлсэн: C-compliant, Дийлэнхийг биелүүлсэн: LC-largely compliant, Хэсэгчлэн биелүүлсэн: PC-partially compliant, Биелүүлээгүй: NC-noncompliant/

Зөвлөмж 1	Зөвлөмж 2	Зөвлөмж 3	Зөвлөмж 4	Зөвлөмж 5	Зөвлөмж 6	Зөвлөмж 7	Зөвлөмж 8
PC	LC	LC	LC	LC	LC	LC	PC
Зөвлөмж 9	Зөвлөмж 10	Зөвлөмж 11	Зөвлөмж 12	Зөвлөмж 13	Зөвлөмж 14	Зөвлөмж 15	Зөвлөмж 16
LC	LC	C	LC	LC	PC	LC	LC
Зөвлөмж 17	Зөвлөмж 18	Зөвлөмж 19	Зөвлөмж 20	Зөвлөмж 21	Зөвлөмж 22	Зөвлөмж 23	Зөвлөмж 24
LC	LC	LC	LC	C	LC	LC	LC
Зөвлөмж 25	Зөвлөмж 26	Зөвлөмж 27	Зөвлөмж 28	Зөвлөмж 29	Зөвлөмж 30	Зөвлөмж 31	Зөвлөмж 32
LC	LC	LC	PC	C	C	C	LC
Зөвлөмж 33	Зөвлөмж 34	Зөвлөмж 35	Зөвлөмж 36	Зөвлөмж 37	Зөвлөмж 38	Зөвлөмж 39	Зөвлөмж 40
LC	LC	PC	C	C	LC	LC	LC

Эх сурвалж: Монгол Улсын 2 дахь шатны Явцын тайлан

